

ТӨРИЙН ӨМЧИТ ОЛБОРЛОХ КОМПАНИД ЗОРИУЛСАН ИЛ ТАЙЛАГНАЛЫН ХӨТӨЧ

2018 ОНЫ НЭГДҮГЭЭР САР



Танилцуулга

ӨМНӨТГӨЛ

2017 оны Баялгийн засаглалын индекс (БЗИ)-т нийт 81 төрийн өмчит компани (ТӨК) хамрагдсанаас зөвхөн ес нь ил тод, хариуцлагатай засаглалын стандартыг зохих түвшинд (авбал зохих 100 онооноос 75-с дээш оноотойгоор) хангасан үнэлгээ авчээ.

Байгалийн баялаг ихтэй улсуудын хувьд төр засаг олборлолтыг хэрхэн удирдан зохицуулж, хэдий хэмжээний орлого олох нь ТӨК-уудын үйл ажиллагаанаас ихээхэн хамаардаг тул тэдний нийгэм, эдийн засагт бүхэлд нь үзүүлэх нөлөө их байдаг. БЗИ нь төрийн өмчит компаниудын үйл ажиллагаа, бодит орлогын талаар мэдээлэл дутмаг байгаа орон зайг нөхөх зорилго агуулж буй бөгөөд энэ асуудлаар тодорхой ойлголт олж авахад тус дөхөм болох эх сурвалж юм. Төрийн өмчит компаниуд мэдээллээ олон нийтэд тайлагнах явдлыг нэмэгдүүлэх замаар буй болгосон ил тод байдал нь хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагчид, бизнесийн түншүүд болон үйл ажиллагаа нь улам бүр идэвхжих болсон иргэний нийгмийн өмнө тэдний зүгээс хүлээх хариуцлагын чухал бүрэлдэхүүн хэсэг билээ.

Олборлох салбарын төрийн өмчит зарим компаниуд нийтэд тайлагнаж буй мэдээллээ тоо болон чанарын хувьд сайжруулахад анхаарч чамгүй хөрөнгө оруулах болсон бөгөөд тодорхой заасан шаардлага, заавар, зөвлөмжийн дагуу мэдээллээ бэлддэг аж. Түүнчлэн зарим ТӨК-ийн хувьд хувийн хэвшлийнхний мөрддөг нягтлан бодох бүртгэлийн дүрэм журам, хөрөнгийн бирж дээр хувьцаа гаргахад дагах зохицуулалт, шаардлагуудад захирагдах ёстой байдаг. Цаашилбал, сүүлийн жилүүдэд Дэлхийн Банк, Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн Байгууллага (ЭЗХАХБ) зэрэг олон улсын байгууллагууд ТӨК-уудын ил тайлагналтай холбоотой сайн туршлагын талаар хэд хэдэн сурвалж бичгийг нийтлээд байна.¹ Төрийн өмчит уул уурхайн компаниудын ил тод байдлыг хангахтай холбоотой шилдэг туршлагын тухайд 2016 онд гарсан Олборлох Үйлдвэрлэлийн Ил Тод Байдлын Санаачилга (ОУИТБС)-ын Стандартад тус санаачилгад оролцогч 50 гаруй орны ТӨК-уудын биелүүлэх шаардлага, зөвлөмжүүдийг тусгасны дотор бенефициар өмчлөгчид буюу ашиг хүртэгч эцсийн эзэд, бүтээгдэхүүний борлуулалт, орлогын шилжүүлгүүд, мөн төсвийн шинжтэй зарцуулалтын талаарх мэдээллийг ил тайлагнах шаардлагыг тусгажээ. Түүнчлэн Баялгийн засаглалын индекс нь бүтээгдэхүүн үйлдвэрлэл, түүхий эдийн борлуулалт, хамтарсан ба охин компаниудад оролцох оролцоо болон бусад асуудлууд багтсан 10 үзүүлэлтээр ТӨК-уудын ил тод байдал, засаглалд үнэлгээ өгсөн.

ЭХ СУРВАЛЖУУД

Олборлох салбарт үйл ажиллагаа явуулж буй ТӨК-ийн ил тайлагналыг хэвшүүлэхэд дөхөм болох зорилготой уг хөтөч нь ТӨК-уудын тайлагналтай холбоотой янз бүрийн эх сурвалжаас олж цуглуулсан сайн туршлагын тухай мэдээллийг нэгтгэн хүргэснээр тэдгээр компаниудын ил тайлагналаа сайжруулах ажилд нь дэм үзүүлэх санаа агуулсан болно. Энэхүү хөтчийн агуулга нь ОУИТБС-ын Стандарт, БЗИ, түүнчлэн

¹ Дэлхийн Банк, Төрийн өмчит аж ахуйн нэгжийн компанийн засаглал: арга хэрэгсэл(2014), doi: 10.1596/978-1-4648-0222-5; ЭЗХАХБ, ЭЗХАХБ-ын Төрийн өмчит аж ахуйн нэгжийн компанийн засаглалын гарын авлага (2015), <http://dx.doi.org/10.1787/9789264244160-en>.

Агуулга

Танилцуулга	2
I. Юуг ил тод болгох вэ?	5
Бүлэг 1: Салбарын нөхцөл байдал	5
Бүлэг 2: Хэтийн зорилго, бүтэц, зохион байгуулалт ..	8
Бүлэг 3: Үүрэг	14
Бүлэг 4: Гүйцэтгэл, үр дүн	17
Бүлэг 5: Засгийн газрын болон нутгийн удирдлагын байгууллагуудтай хийх шилжүүлэг	21
Бүлэг 6: Үр нөлөө ..	22
II. Мэдээллийг хэрхэн ил тод болгох вэ?	23

Дэлхийн Банк, ЭЗХАХБ, Транспарэнси Интернэшнл² зэрэг байгууллагаас эрхлэн гаргасан Төрийн өмчит компаниудад зориулсан ил тайлагналын нийтлэг удирдамж болон тайлангууд, ТӨК-ийн ил тод байдал, ил тайлагналын тухай ББЗХ-ийн бэлтгэн нийтэлсэн хэд хэдэн орны тайлан³ болон тодорхой улс орны туршлагыг судалсан ажил, түүнчлэн ТӨК-уудын жилийн тайлан, цахим хуудас, бусад ил тайлагнасан мэдээлэлд үндэслэн тодруулсан сайн туршлагын дүн шинжилгээнд суурилсан болно.

ХАМРАХ ХҮРЭЭ

Уг хөтөч нь ТӨК-уудын хувьд олон нийтэд мэдээллээ ил тайлагнахдаа ашиглах практик лавлагаа болох боломжтой юм.

Гэхдээ ТӨК-ууд янз бүрийн хэлбэрээр оршиж, харилцан адилгүй нөхцөлд үйл ажиллагаа явуулахын сацуу эрх зүйн өөр өөр орчинд захирагдан маш олон талуудад нөлөө үзүүлж байдаг тул санхүүгийн болон бусад мэдээллийг ил тайлагнахад дагах бүх ТӨК-д хамааралтай нэг хэвийн загвар, маягт байх боломжгүйг тэмдэглэх нь чухал.

Иймд улс бүрд байх өөрийн онцлогтой хууль тогтоомж, зохицуулалтын шаардлагад нийцэх явдлыг хангах болонил тод байдалд хүрэх цорын ганц арга замыг зааж тодорхойлохыг уг хөтөч зориогүй. Ийм арга хэрэгслийг олон улсын хэмжээнд үүсгэн ашиглахад түвэгтэй бөгөөд харин тодорхой нэг улсад зориулан боловсруулж, ашиглаж болох юм. Улмаар шаардлага, тогтсон уламжлал, эсхүл хэрэгжүүлэхийг дэмжсэн сайн туршлага хэлбэрээр ТӨК ил тайлагнах ажилдаа тусгавал зохих зүйлсийн жагсаалт, чиг хандлагуудыг уг хөтөчид танилцуулсан болно. ТӨК-уудын мэдээллээ ил тайлагнах практикт чухал ахиц дэвшил гаргахад дэмжлэг үзүүлэхийг уг хөтөч зорьж байгаа хэдий ч ТӨК болгон өөрт хамааралтай талуудыг тодорхойлж, улмаар тэдгээрийн сонирхол, асуудлуудыг зохих түвшинд хариулах явдлыг ил тайлагналаар хангах хэрэгтэй.

Хөтчийн зорилго нь төрийн өмчит уул уурхайн компаниудын ил тод байдлыг сайжруулах замаар хариуцлагыг дээшлүүлэх явдал хэдий ч сүүлийн үеийн бодит жишээнүүдээс⁴ харахад ил тод байдал дангаараа сайн засаглалын баталгаа болж чадахгүй нь тодорхой байна. Гэхдээ ил тод байдал бол сайн засаглалын нэг чухал тулгуур багана мөнөөс мөн агаад хариуцлага бий болгоход гарцаагүй шаардлагатай алхам юм.

Ил тод байдал нь төрийн өмчит компанийн байгууллагын соёлын нэг хэсэг болоод зогсохгүй үйл ажиллагааных нь бүхий л түвшинд үйлчилдэг болж чадвал хамгийн үр дүнтэй. Иймд ТӨК-ууд ил тод байдлыг өдөр тутмын дадал болгож хэвшүүлэхэд анхаарахыг хөтөч онцолж байна. Хуучирч хоцорсон бөгөөд гол үйл ажиллагаатай нь хамаагүй мэдээлэл бүхий тайлан гаргахын оронд ТӨК-ууд системтэй бөгөөд стандартчилсан байдлаар ил тод байдлыг хангах хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, бүрэн бүтэн, нарийвчлалын хувьд шаардлага хангахуйц мэдээллийг ТӨК зохих давтамжтайгаар, байнга шинэчлэн, нээлттэй хэлбэрээр сонирхогч талуудад хүртээмжтэйгээр хүргэх, мөн ТӨК-ийн өдөр тутмын үйл ажиллагааны дэгтэй бүрэн

2 Дэлхийн Банк, Компанийн засаглал; ЭЗХАХБ, ЭЗХАХБ-ын Хөтчүүд; Транспарэнси Интернэшнл, Компанийн тайлангийн ил тод байдал: шинэ зах зээл дээр үйл ажиллагаа явуулж буй олон улсын компаниудын үнэлгээ (2016), http://files.transparency.org/content/download/2025/13112/file/2016_TransparencyInCorporateReporting_EMMs_EN.pdf.

3 Байгалийн Баялгийн Засаглалын Хүрээлэн, Гэрээний удирдлагатай холбоотой олон улсын сайн туршлагауд (2016); Давид Манли and ВэббиВэйк, Зэсийн салбарын томоохон компаниуд: Конго, Замби улсуудын Төрийн өмчит уул уурхайн компаниудын сургамж (Байгалийн Баялгийн Засаглалын Хүрээлэн, 2015); Аарон Сайн, Александра Жиллис, Кристина Кацурис, Inside НҮГТК-ийн газрын тосны борлуулалт: Нигерид шаардлагатай шинэчлэл (Байгалийн Баялгийн Засаглалын Хүрээлэн, 2015).

4 Жишээ нь, Бразил Улсын ТӨК Петробрас авлигын асуудалд холбогдсоор байгаа ч ил тод байдлаа нэлээд сайжруулж чаджээ.

уялдсан байдлаар ил тайлагнах ажлыг дадал болгон хэвшүүлэх⁵ нь зүйтэй гэж зөвлөж байна. Өгөгдөл мэдээллийг системтэйгээр цуглуулж, автоматаар ил болгодог ил тайлагнах үйл явцыг үйл ажиллагаандаа хэвшүүлэх нь мэдээллийн жигд, үр ашигтай байдлыг нэмэгдүүлнэ.

ЗОРИЛТОТ УНШИГЧ

Уг хөтчөөр байгууллагынхаа ил тод байдал, засаглалыг сайжруулах зорилгоор ил тайлагнавал зохих мэдээллийг авч үзэх хүрээг ТӨК-ийн шийдвэр гаргагчдад санал болгож байна. Түүнчлэн ТӨК-ийн ил тайлагнах явдалд мониторинг хийж үнэлгээ өгөх сонирхолтой иргэний нийгмийн байгууллагууд, парламентын хороод зэрэг хяналтын үүрэг гүйцэтгэгч талууд хөтчийг ашиглах боломжтой. Тухайн улсын ТӨК-ийн үйл ажиллагааг харьцуулан үзэж, улмаар түүнд холбогдох зөвлөмжүүд болгон хувиргаж болох олон улсын сайн туршлагаудыг уг хөтчид танилцуулсан болно.

БҮТЭЦ

Энэхүү хөтчид ил тайлагналын цар хүрээ (буюу ямар мэдээллийг ил тайлагнах), түүнчлэн ТӨК мэдээллээ ил тайлагнах аргачлалаа боловсруулахад баримтлах гол зарчим, арга барил (буюу хэрхэн тайлагнах)гэх хоёр асуудлыг аль алиныг нь хөндсөн. Хүснэгт 1-д ТӨК юуг тайлагнавал зохих талаарх зөвлөмжийг харуулав.

Хүснэгт 1. Тайлагнавал зохих мэдээллийн тойм

ТӨК-ийн ил тайлагнах мэдээллийн бүлэг	Агуулга	Онцлог
Салбарын нөхцөл байдал	Хууль, эрхзүйн болон институцийн нөхцөл	
	Улс төр, эдийн засаг, нийгэм, байгаль орчны нөхцөл	
Хэтийн зорилго, бүтэц, зохион байгуулалт	Зорилго	Хүртээмж
	Өмчлөл (үүнд ашиг хүртэгч эзэд буюу бенефициар өмчлөгчийн мэдээлэл багтана)	
	Компанийн бүтэц	
	Хүний нөөц	Найдвартай байдал
	Түншлэгчид	Жигд байдал
	Компанийн засаглал	
Гүйцэтгэх үүрэг	Бизнесийн үйл ажиллагаа	Бүрэн бүтэн байдал
	Бизнесийн бус үйл ажиллагаа	
	Гэрээ, хэлэлцээрүүд	Давтамж
Гүйцэтгэл, үр дүн	Гүйцэтгэл (үүнд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, борлуулалт, үр ашиг гэх мэт)	Цаг үеэ олсон байдал
	Санхүүгийн үр дүн	
Засгийн газар болон орон нутгийн төр захиргааны байгууллагуудтай хийсэн шилжүүлэг	Засгийн газар болон орон нутгийн төр засгийн байгууллагад хийсэн төлбөр, тэдгээрээс хүлээн авсан орлого	
Үр нөлөө	Нийгэм, байгаль орчин, хүний эрхэд нөлөөлөх байдал, компанийн нийгмийн хариуцлагын хүрээний санаачилгууд	

5 ОУИТБС-аас практикт хэвшүүлэх гэснийг "ил тод байдлыг засаглал, удирдлагын тогтолцооны салшгүй бүрэлдэхүүн хэсэг, тогтвортой шинж чанар болгож чадсан улсуудыг урамшуулж дэмжих явдал" гэж тодорхойлжээ. <https://eiti.org/mainstreaming> үзнэ үү.

I. Юуг ил тод болгох вэ?

Тайлагнал үнэ цэнэтэй байхын тулд тухайн ТӨК-ийн үйл ажиллагаанд хамааралтай талуудад (тухайлбал, хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагчид, бодлого боловсруулагчид, татвар төлөгчид, иргэний нийгмийнхэн, бизнесийн түншүүд гэх мэт) чухал хэрэгцээтэй асуудлуудыг хөндсөн байх учиртай.

Ерөнхийд нь доорх зургаан бүлэгт эдгээр асуудлыг хуваан авч үзэж болно:

- Салбарын нөхцөл байдал
- Хэтийн зорилго, бүтэц, зохион байгуулалт
- Гүйцэтгэх үүрэг
- Гүйцэтгэл, үр дүн
- Засгийн газар болон орон нутгийн төр захиргааны байгууллагуудтай хийсэн шилжүүлэг
- Үр нөлөө

Тус бүрийг нь гүнзгийрүүлэн авч үзэх эдгээр бүлэг асуудлууд нь уг хөтчийн агуулгыг цэгцтэй танилцуулахад чиглэсэн бөгөөд тогтсон ангилал биш болохыг анхаарах хэрэгтэй. Зарим асуудал давхцах тохиолдол гарах бөгөөд энэ нь уншигчийг хязгаарлах зүйл биш юм. Тухайлбал, зарим ТӨК-ийн хувьд удирдах зөвлөлийн гишүүдэд төлөх урамшууллын мэдээллийг компанийн засаглалын бусад мэдээлэлтэй хамтатган тайлагнадаг бол зарим нь үүнийг өөр сувгаар тайлагнаж болно. Үүнд хамгийн чухал нь ил тайлагнасан мэдээлэл өөр хоорондоо авцалдаатай байх явдал юм.

Ямартаа ч энд толилуулсан зургаан бүлэг асуудал нь аливаа ТӨК-ийн хувьд мэдээллээ тайлагнах явдлыг хангахад онцлогтоо тохируулан уян хатан байдлаар ашиглаж болохуйц өргөн хүрээнд томъёологдсон. Зарим ТӨК-ийн хувьд тодорхой бүлэг асуудлууд илүү чухал байж болох агаад тэр дагуу тайлагнах үйл явцаа зохион байгуулах боломжтой. Тухайлбал, хөрөнгийн биржид бүртгэлтэй ТӨК үйл ажиллагаагаа тайлагнах тодорхой шаардлагуудад захирагдах ёстой бол төсвийн шинжтэй үйл ажиллагааг хэрэгжүүлэх үүргийг хүлээдэг ТӨК-ийн хувьд бизнесийн бус чиг үүрэг, тэдгээрийн үйл ажиллагааных нь ерөнхий үр дүнд үзүүлэх нөлөөг тодорхой тайлбарлахад анхаарах шаардлагатай.

БҮЛЭГ 1: САЛБАРЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Энэ бүлэг асуудал нь иргэдэд ТӨК-ийн үйл ажиллагааны цар хүрээ болон стратегийг ойлгоход шаардлагатай ерөнхий нөхцөл байдлыг таниулах зорилготой. Ийм мэдээллийг гол төлөв яамд, зохицуулагч агентлаг зэрэг бусад талууд гаргадаг, эсхүл шинэ дүрэм журам гарах, улс төрийн хямрал үүсэх гэх мэт нөхцөл үүсэхэд мэдээлэл нийтэд ил болдог хэдий ч ТӨК өөрийн тайландаа энэхүү чухал бөгөөд суурь мэдээллийг тусгаснаар оролцогч талууд тухайн компанийн санхүүгийн болон санхүүгийн бус өгөгдөл мэдээллийг зөв ойлгож тайлбарлахад дөхөмтэй.

Дараах мэдээлэл ТӨК-д ихэнхдээ тодорхой байх ба энэ хөтчийн хоёр дахь хэсэгт дурдсан зарчмын дагуу түвэггүй нэгтгэн тайлагнах боломжтой.

1) Хууль эрх зүйн болон институцийн нөхцөл байдал

Энэ төрлийн мэдээллийг авснаар оролцогч талууд олборлох үйлдвэрлэлийн харилцааг зохицуулж буй дүрэм журмын талаар мэдлэгтэй болж, салбарын холбогдох оролцогч талуудын үүргийн талаар ойлголт авна.

а. Хууль, дүрэм журам

ТӨК-т хамаарах хууль, эрх зүйн орчин, татварын тогтолцоо болон бусад дүрэм журам болон практик туршлагын талаар ил тайлагнахыг ОУИТБС шаарддаг. (ОУИТБС-ын шаардлага 2.1.-ийг үзнэ үү.) Яамд, агентлагуудын түвшинд энэ мэдээллийг ихэнхдээ ил болгодог ч ТӨК-үүдийн зүгээс мөн хүргэдэг байх нь сайн туршлагад тооцогдох бөгөөд олон нийтэд тайлагнаж буй бусад мэдээлэлд хамаатай ерөнхий нөхцөл байдлыг тайлбарлахаас гадна хууль, эрх зүйн хүрээ болон практик хэрэгжилтийн хооронд гарах аливаа зөрүүг тодруулах боломжийг олгоно.⁶

ТӨК-ийн ил тайлагнавал зохих мэдээлэлд:

- i Салбарын харилцааг зохицуулж буй хууль тогтоомж (жишээ нь газрын тосны хууль, лиценз олгох үйл явц)
- ii ТӨК-д хамаатай компанийн тухай хууль тогтоомж
- iii ТӨК-ийн ил тайлагнах мэдээллийн талаар зохицуулж буй хууль тогтоомж
- iv ТӨК-ийн дүрэм болон компанийг үүсгэн байгуулсан бусад баримт бичиг
- v Байгаль орчин, нийгэм, эрүүл мэндийн асуудлыг зохицуулсан хууль тогтоомж
- vi Газартай холбоотой эрхийн харилцааг зохицуулж буй хууль тогтоомж
- vii Худалдан авах ажиллагаатай холбоотой хууль тогтоомж
- viii Авлигын эсрэг хууль тогтоомж
- ix Хөдөлмөрийн харилцааг зохицуулж буй хууль тогтоомж

Дотоодын хууль тогтоомжоос гадна ил тайлагнах мэдээлэлд бүсийн болон олон улсын хэм хэмжээ, стандартууд, үүнд тухайлбал Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын найман суурь конвенц, Авлигын эсрэг НҮБ-ын конвенц, Олон Улсын Санхүүгийн Корпорацийн Байгаль орчин, нийгмийн тогтвортой байдлын гүйцэтгэлийн стандарт гэх мэт стандартуудын талаар компанийн баримтлах байр суурийг тусгах боломжтой.

б. Салбарын гол тоглогчид

Тухайн улсын олборлох үйлдвэрлэлд чухал үүрэгтэй гол тоглогчдын нэг нь төрийн өмчит компани байдаг. Иймд салбарын гаднах талуудын хувьд эдгээр тоглогчдын тус бүрийн гүйцэтгэх үүргийн талаар ойлголттой болох нь чухал юм. Ил тайлагнах мэдээлэлдээ ТӨК дор дурдсан этгээдүүдтэй харилцах харилцаагаа тайлбарлах ёстой ба үүнд хөдөлмөрийн болон хяналтын чиг үүргийн хуваарь⁷, бизнесийн харилцаа болон бусад хамтын ажиллагааг тусгана:

- x Засгийн газрын яам, агентлаг
- xi Бусад ТӨК
- xii Парламентын бүтцийн байгууллагууд (жишээ нь салбарын хороод)
- xiii Хувийн хэвшлийн чухал оролцогч талууд (жишээ нь ТӨК-тэй хамтарсан төслүүд эсхүл ашиг хуваах гэрээнд түншлэн оролцогч компаниуд)⁸

6 Норвеги, Чилийн жишээг сайн жишээ болгон дурдаж болно. Статойл (Statoil), 2016 Жилийн тайлан (2016), 37–39, <https://www.statoil.com/content/dam/statoil/documents/annual-reports/2016/statoil-2016-annualreport-20-F.pdf> and Codelco, 2016 Annual Report (2016), 26, <https://www.codelco.com/memoria2016/en/pdf/annual-report/annual-report-2016.pdf>.

7 Коделко (Codelco) хяналтын чиг үүрэг хэрэгжүүлдэг байгууллагуудыг нэрлэсэн жагсаалтыг нийтэлж, аудитад оролцоотой зарим хороодын талаар мэдээлэл өгсөн байдаг. Коделко 2016 оны Жилийн тайлан(2016), хуудас 27 болон 44.

8 Коделко (Codelco) хяналтын чиг үүрэг хэрэгжүүлдэг байгууллагуудыг нэрлэсэн жагсаалтыг нийтэлж, аудитад оролцоотой зарим хороодын талаар мэдээлэл өгсөн байдаг. Коделко 2016 оны Жилийн тайлан(2016), хуудас 27 болон 44.

xiv Зохицуулалтын болон хяналтын чиг үүрэг гүйцэтгэгч холбогдох бусад этгээд (татварын алба, байгаль орчны зохицуулагч, аудитын байгууллага, омбудсмэн, авлигын эсрэг хороод гэх мэт)

Түүнчлэн бусад төрийн байгууллагууд, ялангуяа салбарын удирдлагад шууд оролцоотой яам, агентлагуудын зүгээс ТӨК-ийг хянах журам, ТӨК-ийн үйл ажиллагаа, гүйцэтгэлтэй холбоотой мэдээллийг ил нийтэлснээр ТӨК-ийн гүйцэтгэх үүргийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэхэд хувь нэмрээ оруулна.

2) Улс төр, эдийн засаг, нийгэм, байгаль орчны нөхцөл байдал

Улс төр, эдийн засаг, нийгэм, байгаль орчны хүчин зүйлс бүгд ТӨК-ийн үйл ажиллагаа, үр дүнд нөлөөлж байдаг бөгөөд зарим тохиолдолд эрсдэлийн чухал хүчин зүйлс ч болох талтай. Ил тод байдлыг хангахад дан тоон мэдээллээр бүрдүүлж эс чадах ойлгомжтой байдлыг бий болгох шаардлагатай. Нөхцөл байдлыг тайлбарласан чанарын мэдээлэл нь ил тод байдлыг хангахад статистик мэдээлэлтэй нэгэн адил ач холбогдолтой. Доор өгүүлсэнчлэн тогтмол болон хувьсах мэдээллийг аль алиныг ил тайлагнах нь сайн туршлагад тооцогдоно.⁹

а. Тогтмол мэдээлэл

- i Тухайн улс орны олборлох салбарын тойм, түүх
- ii Эрсдэлийн холбогдох хүчин зүйлс (жишээ нь улс төрийн, зохицуулалтын, хууль эрх зүйн, зах зээлийн эрсдэлүүд, өрсөлдөөн, зөрчилдөөн болон аюулгүй байдалтай холбоотой асуудлууд, гео-политикийн эрсдэл, цаг агаарын нөхцөл байдал, үнийн савлагаа)


б. Хувьсах мэдээлэл

- i Салбарт нөлөөлж буй улс төрийн болон эдийн засгийн гол өөрчлөлтүүд
- ii Хууль, эрх зүйн орчны өөрчлөлт (жишээ нь хувьчлал, зохицуулагч шинэ агентлаг байгуулагдах гэх мэт)
- iii Зохицуулагчийн явуулж буй мөрдөн шалгалт эсхүл хууль хяналтын байгууллагад үүссэн хэргүүд
- iv Түүхий эдийн савлагаа (жишээ нь үнэ, нөөцийн хэмжээ, бүтээгдэхүүний хэмжээ гэх мэт)
- v Сүүлийн үеийн чухал үйл явдлууд (үүнд цаг агаарын холбогдолтой үйл явдал, авлигатай холбоотой дуулиан, техникийн шинжтэй ноцтой асуудал, үйлдвэрийн томоохон осол, гэрээг дахин хэлэлцэх үйл явц гэх мэт)
- vi Бусад боломж болон сорилт бэрхшээл

ТӨК нь хувьсах мэдээллийг энэ хөтчийн хоёрдугаар хэсэгт тайлбарласны дагуу зохих давтамжтайгаар, цаг хугацаанд нь ил тайлагнадаг байвал зохино.

Чили улсын ТӨК болох Коделко тухайн жилийн онцлох мэдээллийг жилийн тайландаа хэрхэн оновчтой тусгах сайн жишээг үзүүлж байна.

9 Коделко (Codelfco), 2016 оны жилийн тайлан(2016), хуудас 28–29.



Зураг 1. Коделко-ийн 2016 оны жилийн тайланд туссан онцлох үйл явдлууд

Эх сурвалж: Коделко ТӨК-ийн 2016 оны жилийн тайлан, хуудас 32

БҮЛЭГ 2: ХЭТИЙН ЗОРИЛГО, БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Зарим ТӨК бүтэц, компанийн засаглалын талаарх мэдээллээ ил тайлагнасан байдаг. ТӨК-ийн хэтийн зорилго болон чиг үүрэг, түүний дотор бизнесийн болон бизнесийн бус зорилтуудын талаар тодорхой ойлголттой болох нь оролцогч талуудад ач холбогдолтой байдаг.¹⁰

1) Зорилго

ТӨК-ийн хэтийн зорилго, зорилтууд болон нэн түрүүнд анхаарах асуудлуудыг компанийн удирдлагын түвшинд гаргах чиг үүргийн талаарх мэдэгдэлд бизнесийн болон бизнесийн бус зорилгын хамтаар танилцуулах боломжтой. Түүнчлэн ТӨК-ийн дунд болон урт хугацааны гүйцэтгэлийн зорилго болон зорилтуудын талаарх тоон мэдээллийг ил тайлагнах боломжтой.

10 Статойл(Statoil), 2016 оны жилийн тайлан(2016), хуудас 13–16.

2) Өмчлөл

ТӨК дараах асуудлаар үнэн зөв бөгөөд шинэчлэгдсэн мэдээллийг ил тайлагнавал зохино:

- i Өмчлөлийн бүтэц болон зохицуулалтууд (үүнд өмчлөлийн чиг үүрэгтэй холбоотой үүсэх эрх, бусад үйл явц, тухайлбал санал өгөх тогтолцоо гэх мэт)
- ii Компанийн хувьцаа бүртгэгдсэн биржүүдийн жагсаалт
- iii Капиталын бүтцэд гарсан өөрчлөлт ба өмчлөл¹¹
- iv Хувьцаа эзэмшигчдийн талаарх эзэмшиж буй хувьцааны төрөл, тоо хэмжээ зэргийг агуулсан мэдээлэл.

Хэсэгчлэн хувьчлагдсан ТӨК-уудын хувьд дээрх жагсаалтын сүүлд дурдсан мэдээллийг ил тайлагнахдаа хувийн эзэмшлийн хувьцааны ашиг хүртэгч буюу бенефициар өмчлөгчийн¹² талаар тусгах шаардлагатай. ОУИТБС-ын Стандартын 2.5-д зааснаар ТӨК-ууд дараах мэдээллийг ил тод болгох ёстой. Үүнд: (1) төрөөс бусад бенефициар өмчлөгчийн нэр, үндэс угсаа, оршин суух улс орон, түүнчлэн улс төрийн нөлөөтэй этгээдийн мэдээлэл болон албан тушаал (ОУИТБС-ын Стандартын 2.5. с-д туссан ил тайлагнах шаардлага), түүнчлэн үндэсний биеийн байцаалтын дугаар, төрсөн огноо, хаяг болон холбоо барих мэдээлэл (ОУИТБС-ын Стандартын 2.5. d-д туссан ил тайлагнах зөвлөмж); (2) эзэмшлийн хэмжээ; мөн (3) өмчлөл эсхүл хяналтыг хэрхэн хэрэгжүүлдэг талаарх мэдээлэл (жишээ нь хувьцааны тоо, шууд болон шууд бусаар санал өгөх эрхгэх мэт).

3) Компанийн бүтэц

ТӨК төвлөрсөн тогтолцоотой байж эсхүл салбар компаниудын сүлжээгээр дамжуулж үйл ажиллагаагаа явуулж болно. Ямар хэлбэртэй байхаас үл хамааран (уул уурхайн болон уул уурхайн бус) бодит үйл ажиллагаа болон санхүүгийн урсгалын түвэгтэй нийлмэл байдалд компанийн бүтэц нөлөөлдөг. ОУИТБС-ын Стандартын 2.6. b-д заасны дагуу ТӨК нь тухайн улсад үйл ажиллагаа явуулж буй уул уурхай, газрын тос болон байгалийн хийн компаниудад эзэмших өөрийн бөгөөд охин ба хамтарсан компаниудын хувь эзэмшлийн түвшинг ил тайлагнах үүргийг хүлээдэг. Ерөнхийдөө ТӨК-ууд толгой болон охин компаниудын талаар дор жагсаасан мэдээллийг ил тайлагнах хэрэгтэй:

- i Компанийн нэр
- ii Компанийг үүсгэн байгуулсан хаяг
- iii Дээд түвшний удирдлагын талаарх мэдээлэл (нэр, товч намтар) (Зураг 2-с Норвегийн жишээг үзнэ үү)
- iv Компанийн гол чиг үүргийг тусгасан бүтцийн бүдүүвч¹³
- v Бүлгийн охин компаниудын жагсаалт (үүнд охин компани тус бүрийн хувьд албан ёсны нэр, байгуулагдсан огноо ба байршил, хуулийн этгээдийн төрөл, 100% ба хэсэгчлэн өмчлөх охин компаниудын өмчлөлийн талаарх мэдээлэл орно)

11 Жишээлбэл, Энэтхэгийн ТӨК ONGC жилийн тайландаа хаана хувьцаа эзэмшиж буй мэдээллээ нийтэлдэг. ONGC, 2014–2015 оны Жилийн тайлан (2016), хуудас 100, http://www.ongcindia.com/wps/wcm/OngcHTML/Annual_Report_2014_15/images/AR-14-15.pdf.

12 Бенефициар өмчлөгч гэдэг нь тухайн аж ахуйн нэгжийг шууд болон шууд бусаар эзэмшдэг, хянадаг, ашиг хүртдэг этгээдийг хэлнэ. Олон нийтэд нээлттэй хөрөнгийн зах зээл дээр гарсан компани, тэдний салбар компаниас хөрөнгийн зах зээлийн нэрийг ил тод болгох, өөрсдийн гарсан хөрөнгийн зах зээлийн файлд нэвтрэх холбоосыг оруулахыг шаарддаг. (ОУИТБС. 2.5. f. iii).

13 Тухайлбал, Коделко (Codelco) 2016 оны Жилийн тайландаа ТӨК-ийн дээд удирдлагын танилцуулгыг нийтэлжээ. Коделко, 2016 оны Жилийн тайлан (2016), хуудас 19.

- vi Үйл ажиллагаа болон ажиллаж буй улс орнууд¹⁴
- vii Төрийн өмчлөлийн хувь хэмжээ болон нөхцөлүүд (жишээ нь бүрэн хэмжээгээр төлж эзэмшсэн хувьцаа, үнэ төлбөргүй эзэмших хувьцаа, бусдаар даалган санхүүжүүлэх хувь хэмжээ гэх мэт), түүнчлэн дээрх “Өмчлөл” хэсэгт дурдсан мэдээлэл (ОУИТБС-ын Стандартын 2.6. b-г үзнэ үү)
- viii Өмчлөлд өөрчлөлт ороход хүргэх хэлцлүүдийн нөхцөлүүд (ОУИТБС-ын Стандартын 2.6. b-г үзнэ үү)

Норвегийн ТӨК болох Статойл цахим хуудсандаа компаниас гадуур хашдаг албан тушаал, төрсөн огноо, ТӨК-д эзэмшдэг хувьцаа, боловсрол болон туршлага, түүнчлэн гүйцэтгэх удирдлагын хороо, удирдах зөвлөл, эсхүл компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын гишүүдтэй гэр бүл, ураг төрлийн холбоотой эсэх талаарх мэдээлэл бүхий товч намтрыг бизнесийн чиглэл тус бүрийг толгойлогчийн хувьд мэдээлсэн байдаг.

Organisation

Statoil consists of eight business areas, staffs and support divisions.

CEO Chief Executive Officer Eldar Sætre Stavanger	COO Chief Business Officer Jensicke Nilsen Stavanger	CFO Chief Financial Officer Håns Jakob Høge Stavanger	LEG Legal Hans Henrik Kjaerum Stavanger	CCOM Corporate Communications Bakke Gjermund Oslo	COA Business Affairs Jan Arnt Jacobsen Oslo	CPL Corporate Planning and Leadership Magne Hovden Stavanger
-------------------------------------------------------------------	----------------------------------------------------------------------	-----------------------------------------------------------------------	---------------------------------------------------------	-------------------------------------------------------------------	-------------------------------------------------------------	------------------------------------------------------------------------------

Eldar Sætre
President and Chief Executive Officer since 15 October 2014

External offices: Member of the board of Strømsberg Gruppen AS and Traceler AS.

Year of birth: 1956

Position: President and Chief Executive Officer since 15 October 2014.

Number of shares in Statoil ASA: 47,882 (as of December 31, 2016).

Loans from Statoil: None

Experience: Joined Statoil in 1980. Executive vice president and CFO from October 2003 until December 2010. Executive vice president for Marketing, processing & renewable energy from 2011 until 2014.

Education: MA in Business Economics from the Norwegian School of Economics and Business Administration (NHH) in Bergen.

Family relations: No family relations to other members of the CEO, members of the Board or the Corporate Assembly.

Зураг 2. Норвегийн ТӨК болох Статойл-ийн албан ёсны цахим хуудсын “Зохион байгуулалт” хэсэг

Эх сурвалж: “Зохион байгуулалт”, Статойл (Statoil), 2017 оны 12-р сарын 6-нд хандсан байдлаар, <https://www.statoil.com/en/about-us/organisation.html>.

4) Хүний нөөц

ТӨК-ийн ажиллах хүчинтэй холбоотой мэдээллийг ил тайлагнах нь сайн туршлагад тооцогдоно. Ил тод ТӨК-уудын ил тайлагнадаг нийтлэг мэдээлэлд дараах орно:

- i Ажиллагсдын тоо (хэсэг нэгж, дотооддоо эсхүл гадаадад, бүтэн эсхүл хагас цагаар, охин компани эсхүл бусад нэгжид ажиллаж буй байдлаар)¹⁵
- ii Жендерийн тэгш байдал
- iii Солигдох хөдөлгөөн
- iv ТӨК-ийн дотоод болон гадаад ажиллагсдын хувь хэмжээ
- v Ажиллагсдын нас (жишээ нь 35-с дээш болон доош насны гэх мэт)
- vi Ажиллагсдын боловсролын түвшин (дээд боловсролтой, бүрэн дунд боловсролтой гэх мэт)
- vii Хүний нөөцийн бодлого (ажилд авах, сургах, үнэлгээ хийх, ажлын байрыг хадгалах, цалин хөлс болон урамшуулал гэх мэт)
- viii Үйлдвэрчний эвлэл болон ажилчдын төлөөллийн бусад байгууллагуудтай харилцах байдал
- ix Олон нийтийн үйл ажиллагаа, санаачилгууд (сургуулийн дараах боловсрол, аюулгүй ажиллагааны хөтөлбөр гэх мэт)

14 Жишээлбэл, Статойл (Statoil) ТӨК-ийн цахим хуудсанд “Бидний тухай” гэсэн гарчиг бүхий мэдээлэл байна <https://www.statoil.com/en/where-we-are.html#norway>.

15 Тухайлбал, Экопетрол (Ecopetrol), 2015 оны Тогтвортой байдлын тайлан, хуудас 363–382, <http://www.ecopetrol.com.co/english/Ecopetrol-Sustainability-Report-2016.pdf>.

- х Эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны талаарх бодлого, стратеги, үзүүлэлтүүд. (Зураг 3-ыг үзнэ үү.)

Occupational safety is a top priority for KMGEP's management. During the last four years the Company has conducted several large-scale initiatives aimed at maintaining employees' safety. In the first instance, this involves improving working conditions, including the construction of service and utility complexes, canteens, administrative complexes, and operators' cabins for the various Group units. Management also pays great attention to the quality of bought-in specialist work clothing, safety footwear, and personal protective equipment.

Expenditure on Health & Safety million tenge		
Expenditure on Health & Safety, industrial and fire protection	2015	2016
OMG	698	789
EMG	236	409
KBM	565	336
KGM	279	341
Subtotal	1,778	1,875
Expenditure on procurement of personal protective equipment	2015	2016
OMG	1,030	1,059
EMG	364	341
KBM	190	188
KGM	54	106
Subtotal	1,638	1,694
Total amount	3,416	3,569

Зураг 3. Казахстаны ТӨК болох КМГ-ийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагаанд зарцуулсан хөрөнгийн тайлан мэдээлэл

Эх сурвалж: КМГ, 2016 оны Жилийн тайлан, 80, https://www.kmgep.kz/eng/investor_relations/annual_reports.

5) Түнш, хамтрагчид

ТӨК-ууд нь хамтарсан компани эсхүл ашиг орлого хуваах бусад хэлэлцээрүүдээр дамжуулан холбогдсон янз бүрийн түншүүдтэй хамтран ажилладаг. Нэгтгэлд бүрэн хамрах охин компаниудыг бодвол эдгээр нь ТӨК-өөс тодорхой хэмжээнд хараат бус байдаг. Худалдан авагчид, гэрээт компаниуд зэрэг бусад талууд ч ТӨК-ийн үйл ажиллагааны тогтолцооны нэгэн хэсэг болдог. Эдгээр харилцааны мөн чанар, бүтэц, мөн ТӨК-ийн түншүүд хэн болох нь компанийн гүйцэтгэлд шууд нөлөөлөх бөгөөд эрсдэл, үр ашиггүй байдал үүсгэх чухал эх сурвалж болдог аж.

Түншлэл, гэрээ хэлэлцээрийн ангилал нь ТӨК-ийн гүйцэтгэх чиг үүргээс хамааран харилцан адилгүй байх ба мэдээллийг ил тайлагнахдаа үүнийг харгалзан үзэх боломжтой.¹⁶ Дараах мэдээллийг ил тайлагнаснаар ТӨК-ийн түншүүдийн ил тод байдлыг нэмэгдүүлэх юм. Үүнд:

- i Бизнесийн түншийн нэр¹⁷
- ii Албан ёсны бүртгэлтэй хаяг
- iii Хөрөнгийн өмчлөл (2-р бүлэг асуудлын 1-р хэсэгт дурдсаныг үзэх), үүнд хамааралтай бол ашиг хүртэгч эздийн талаарх мэдээлэл
- iv Үйл ажиллагаа болон ажиллаж буй улс орнууд
- v Бизнесийн харилцааны мөн чанар (жишээ нь концессын гэрээ, ашиг хуваах хэлцэл, лиценз эзэмшигч, хамтарсан компани, төр-хувийн хэвшлийн түншлэл, гэрээт компани, худалдан авагч гэх мэт)
- vi Түншлэлээс үүдсэн орлого, зарлага (үүнд тухайн улсад үйл ажиллагаа явуулж буй уул уурхай, газрын тос болон байгалийн хийн компаниудад олгосон зээл, гаргасан баталгааны тухай дэлгэрэнгүй мэдээллийг хамруулна) (ОУИТБС-ын Стандарт, 2.6)

16 Тухайлбал, Статойл (Statoil) олон улс оронд байх түншүүдийнхээ жагсаалтыг албан ёсны цахим хуудсандаа "Бид хаана үйл ажиллагаа явуулдаг вэ" гэсэн гарчигтай хэсэгт мэдээлсэн, <https://www.statoil.com/en/where-we-are.html#norway>.

17 Тухайлбал, "Хавсралт E," ONGC (Энэтхэг), 2015 оны Жилийн тайлан (2016), http://www.ongcindia.com/wps/wcm/PDF/AnnualReport/annual_report15-16.pdf; "F-108-110," YPF (Аргентин), 2015 оны Жилийн тайлан (2015), <http://www.ypf.com/enu/InversoresAccionistas/Lists/InformeAnnualForm20/YPF-20F-2015.pdf>; Pertamina (Индонез), 2016 оны Жилийн тайлан (2016), хуудас 114–116, http://www.pertamina.com/media/5e70a57f-e2ec-4429-bbfe-292af2fb7db/AR_Pertamina_2016.pdf.

6) Компанийн засаглал

ТӨК-ийн засаглалын талаарх мэдээлэл нь оролцогч талуудын сонирхлыг хэрхэн тэнцвэржүүлж, дотооддоо үйл ажиллагаа, ажлын горимоо хэрхэн үнэлэн хяналт тавьдаг талаар ойлголттой болоход нэн чухал. Ийм мэдээллийг цогц байдлаар ил тайлагнах нь ТӨК-д институцийн хувьд итгэх итгэл нэмэгдэх сайн нөлөөтэй бөгөөд мэргэжлийн байж хариуцлагатай үйл ажиллагаа явуулах эрмэлзэлтэйг илтгэнэ. Компанийн үйл ажиллагаа ялангуяа улс төрийн нөлөөнд автах явдлыг хязгаарлах арга механизмууд ТӨК-ийн хувьд чухал байдаг. Ихэнх ТӨК-ууд удирдах зөвлөлийнхөө бүрэлдэхүүнийг ил тайлагнасан байдаг¹⁸ ч компанийн засаглалтай холбоотой бусад мэдээллийг нийтэлдэггүй буюу багахан хэсгийг нь л нийтэлдэг аж.

а. Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх дээд удирдлага

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн жагсаалт төдийгөөр хязгаарлалгүйгээр дараах зүйлсийг мөн ил тайлагнавал зохино. Үүнд:

- i Удирдах зөвлөлийн чиг үүрэг, гишүүнд нэр дэвшүүлэх үйл явц зэргийг хамруулсан дүрэм журам ба дэг, мөн нөхөн олговор, зөвлөлөөс гаргах, тэтгэвэрт гарах болон бусад урамшуулал
- ii Удирдах зөвлөлийн хуралдсан тоо, хурлын огноо, жилийн ерөнхий хуралдааны тэмдэглэл¹⁹
- iii Удирдах зөвлөлийн гишүүд болон гүйцэтгэх дээд удирдлагын нэрс (зураг, нас, иргэншил зэргийг мэдээлсэн бол сайн)
- iv Боловсрол, туршлагын талаар тусгасан хувийн намтар²⁰
- v Удирдах зөвлөлийн гишүүд болон удирдах өндөр албан тушаалтанд төлсөн нөхөн олговор
- vi Удирдах зөвлөлийн гишүүдийн (төр засаг, компани болон холбогдох этгээдүүд, үүнд тухайн салбар дахь санхүүгийн ашиг сонирхол бүхий талуудаас) хараат бус байдал
- vii Компанид эзэмшдэг хөрөнгийн тухай мэдээлэл
- viii Компанид ажилласан түүх (үүрэг, огноо)
- ix Удирдах зөвлөлд нэр дэвшсэн, томилогдсон огноо
- x Гишүүдийн ирц, сургалт, үнэлгээ

б. Хороод

Төлөөлөн удирдах зөвлөл нь янз бүрийн тооны хороодын хамтаар ТӨК-ийн үйл ажиллагаанд мониторинг хийж, хяналт тавьдаг.²¹ Үүнтэй холбоотойгоор дараах мэдээллийг ил тайлагнах нь сайн туршлага болно:

- i Хороодын нэр, гүйцэтгэх үүрэг (аудит, эрсдэл, цалин урамшуулал гэх мэт)
- ii Гишүүнчлэл (үүнд гишүүдийн хараат бус байдлын тухай мэдээлэл)
- iii Үйл ажиллагааны тайлан, үүнд хяналт шалгалт хийсэн бол тэр талаарх мэдээлэл
- iv Гол дүгнэлтүүд, стратеги

18 2017 оны БЗИ-ийн тайланд дурдсанаар, үнэлгээнд хамрагдсан 74 ТӨК-иас 60 нь удирдах зөвлөлийн гишүүдийнхээ мэдээллийг ил болгосон байжээ.

19 Жишээ нь, Статойл (Statoil) жил бүрийн ерөнхий хурлын зар, протокол, бичлэг зэргийг өмнөх хурлуудын мэдээлэлтэй хамт цахим хуудсанд байршуулсан байна: <https://www.statoil.com/en/about-us/annual-general-meeting.html#our-shareholders>.


20 Петронас (Petronas), 2016 оны Жилийн тайлан, хуудас 81–89, <http://www.petronas.com.my/investor-relations/Documents/annual-report/PETRONASAnnualReport2016.pdf>.

21 Тухайлбал, Статойл (Statoil)-ын цахим хуудсанд хороодын жагсаалтыг хүлээх үүрэг, гишүүдийн мэдээллийн хамт ил тод мэдээлсэн байна.

в. Журам, ёс зүйн дүрэм

Дотоод журам, зан үйлийн дүрэм нь компанийн засаглалд нөлөөтэй зүйлс мөн. Тэдгээрийн агуулга болон хэрэгжүүлэх явдал нь ТӨК-ийн суурь үнэт зүйлс, дагаж мөрдөх стратегийн чухал үзүүлэлт болдог. Холбогдох журмуудад дараах жишээг дурдаж болно:

- i. Зан үйлийн эсхүл ёс зүйн дүрэм (Зураг 4-г үзнэ үү)
- ii. Хээл хахууль, авлигын эсрэг бодлого, хөтөлбөр²²
- iii. Бэлэг, зочлолтой холбоотой бодлого
- iv. Сонирхлын зөрчлийг зохицуулах журам
- v. Улс төртэй холбоотой хандив дэмжлэгийг зохицуулсан журам
- vi. Аудитын журам
- vii. Худалдан авалтын бодлого эсхүл худалдан авагчийг сонгох журам²³
- viii. Төсвийн шинжтэй зарцуулалттай холбоотой журам
- ix. Хүний эрхийг хангахад баримтлах дүрэм²⁴
- x. Компанийн нийгмийн хариуцлагын бодлого
- xi. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд болон удирдах дээд албан тушаалтнуудад олгох цалин урамшууллын бодлого
- xii. Гомдол гаргах, хүлээн авах механизм (үүнд шүгэл үлээхтэй холбоотой бодлого хамаарна)²⁵



Зураг 4. Петронасын цахим хуудсан дахь Зан үйл болон бизнесийн ёс зүйн журам болон тухайн улсад холбогдох нэмэлт мэдээлэл

Эх сурвалж: “Бизнесийн ёс зүйн дүрэм,” Петронас, сүүлд хандсан огноо 2017 оны 12 сарын 6, <http://www.petronas.com.my/sustainability/governance/BusinessEthics/Pages/code-of-conduct-business-ethics.aspx>.

г. Эрсдэлийн менежмент

Бодлого, дүрэм журам байх нь чухал боловч тэдгээрийн хэрэгжилт хэрхэн хангагдаж байгаа болон ТӨК-ийн дотоод хяналтын механизм нь бодит байдалд үр дүнтэй ажиллаж буй эсэхэд оролцогч талуудын хувьд анхаарлаа хандуулдаг.

22 Жишээлбэл, Экопетрол (Ecopetrol)-ын Авлигын эсрэг хөтөлбөр (2014), [http://www.ecopetrol.com.co/documentos/upload/Mapa_de_Riesgos_y_estrategia-\(english\).pdf](http://www.ecopetrol.com.co/documentos/upload/Mapa_de_Riesgos_y_estrategia-(english).pdf).

23 Тухайлбал, Индонезийн ТӨК Пертамина (Pertamina)-гийн 2016 оны Жилийн тайлан (2016), хуудас 154–157, http://www.pertamina.com/media/5e70a57f-e2ec-4429-bbfe-292af2fbb7db/AR_Pertamina_2016.pdf.


24 Жишээ нь, “Гэрээлэгчдэд зориулсан хүний эрхийг хангах дүрэм”, Петронас (Petronas), сүүлд хандсан огноо 2017 оны 12 сарын 6, http://www.petronas.com.my/investor-relations/Documents/PETRONAS_Contractors_Code_of_Conduct_on_Human_Rights.pdf.

25 Жишээлбэл, Коделко (Codelco)-ын Бизнесийн ёс зүйн дүрэм, гомдол хүлээж авах шууд утас, <https://www.codelco.com/memoria2016/en/pdf/mem2016codelco-values-and-transparency.pdf>.

Иймд ТӨК-ууд дараах мэдээллийг ил тайлагнах нь зүйтэй. Үүнд:

- i. Үүссэн онцгой нөхцөл эсхүл дүрэм журам зөрчигдсөн тохиолдлыг тодорхойлж, тэдгээрийг хянан шалгах болон засч залруулахаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг нарийвчлан танилцуулсан хороодын тайлан, дотоод аудит эсхүл холбогдох кейс судалгаа
- ii. Ажиллагсад болон гэрээлэгчдийг сургалт болон үнэлгээнд хамруулсан талаарх мэдээлэл (жишээ нь авлигатай тэмцэх болон хүний эрхийн асуудлаар)
- iii. Урьдчилан сэргийлэх болон хамгаалах тусгай хөтөлбөрүүд
- iv. Асуудлыг шийдвэрлэх арга хэмжээний төлөвлөгөө²⁶
- v. Бие даасан аудит

Тодорхой жишээ дурдахад, Тотал компани цахим хуудсандаа тулгарч болзошгүй гол эрсдэл, сорилтуудыг жагсаан танилцуулсан байх ба тэдгээртэй холбоотой компанийн зүгээс ямар арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа талаар мэдээлсэн байх аж. Зураг 5-д тус бүлэг компанийн зүгээс уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой баримталж буй стратегийг үзүүлэв.



Зураг 5. Тотал (Total)-ийн цахим хуудсандаа нийтэлсэн уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой баримталж буй стратеги

Эх сурвалж: “Цаг уур,” Total, хамгийн сүүлд хандсан огноо 2017 оны 12 сарын 6, <http://www.sustainable-performance.total.com/en/node/133>.

БҮЛЭГ 3: ҮҮРЭГ

Төрийн өмчит газрын тос, байгалийн хий, уул уурхайн компаниуд янз бүрийн үүрэгтэй бөгөөд зарим нь олборлох үйлдвэрлэлтэй огт холбоогүй байх нь ч тохиолдоно. ТӨК-ийн үйл ажиллагаа, гүйцэтгэлийн талаар тодорхой мэдээлснээр оролцогч талууд чадавхын дутагдал болон үр ашиггүй байгаа талбаруудыг олж харах нөхцөл бүрдэх юм. Түүнчлэн бизнесийн болон бизнесийн бус үйл ажиллагааг ТӨК-ийн ил тайланд ялгаж мэдээлснээр сонирхлын болзошгүй зөрчлийг илрүүлэхэд тустай байх болно.


26 Жишээлбэл, Статойл (Statoil)-ын 2016 оны Жилийн тайлан (2016), Аюулгүй ажиллагаа, хамгаалалт, тогтвортой байдлын талаарх 2. 11-р хэсэг, хуудас 74–77.

1) Бизнесийн үйл ажиллагаа

Олборлох салбарт хайгуул, олборлолт, тээвэрлэлт, борлуулалт, боловсруулалт зэрэг өргөн хүрээний олон үйл ажиллагаа явагдах тул ТӨК чухам бизнесийн ямар үйл ажиллагаа явуулахыг тодорхойлж, тайлбарлах нь чухал. Компанийн үйл ажиллагааг хэд хэдэн янзаар хэсэг бүлэгт хуваах боломжтой. Тухайлбал, ерөнхий бүлэглэлт (урсгалын эх буюу хайх, олборлох үйл ажиллагаа, дунд хэсгийн урсгал буюу бөөнөөр хадгалах, дамжуулах, тээвэрлэх үйл ажиллагаа, доод хэсгийн урсгал буюу жижиглэн үйлдвэрлэх, боловсруулах, түгээх, борлуулах, жижиглэн худалдааны үйл ажиллагаа), үнэ цэнийн хэлхээний дагуу бүлэглэлт (хайгуул, олборлолт, тээвэрлэлт гэх мэт) эсхүл газар зүйтэй холбоотой бүлэглэлт (үйл ажиллагаа явуулж буй газар тус бүрээр) байж болно. Ерөнхийдөө ТӨК гүйцэтгэх бизнесийн үүргээ тайлбарлахын зэрэгцээ тухайн цаг хугацаанд голлон явуулж буй үйл ажиллагаа, тулгарах сорилт бэрхшээл, болзошгүй өөрчлөлтүүдийн талаар мэдээлэх хэрэгтэй. ТӨК-ийн үйл ажиллагааны чиглэл тус бүрээр гүйцэтгэлийн гол үзүүлэлтүүдийг мөн танилцуулах боломжтой.²⁷ Холбогдох бизнесийн үйл ажиллагаанд дараах зүйлс хамарна. Үүнд:

- i Хайгуул
- ii Нөөцийн хөгжүүлэлт
- iii Үйлдвэрлэл
- iv Тээвэрлэлт, хадгалалт
- v Түүхий эдийн борлуулалт
- vi Цэвэршүүлэлт, боловсруулалт
- vii Боловсруулсан түүхий эдийн маркетинг болон борлуулалт
- viii Холбогдох санхүүгийн үйлчилгээ буюу түүнтэй холбоотой үүрэг

Урсгалын эх болон доод хэсгийн үйл ажиллагаагаа дүрс зургаар тодорхой тайлбарлаж харуулсан Малайзийн ТӨК болох Петронасын сайн жишээг дор үзүүлэв.



Зураг 6. 2016 оны жилийн тайландаа танилцуулсан Петронас-ын бизнесийн үйл ажиллагаа

Эх сурвалж: Петронас, 2016 оны Жилийн тайлан, <http://www.petronas.com.my/investor-relations/Documents/annual-report/PETRONASAnnualReport2016.pdf>.

2) Бизнесийн бус үйл ажиллагаа

Бизнесийн бус чиг үүргийг нарийн тодорхойлох нь оролцогч талууд ТӨК-ийн гүйцэтгэлийг үнэлэх, ТӨК-ийн хувьд хариуцлагатай байдлаа сайжруулахад

27 Бүлэг 4-өөс 1(в) -т дурдсан жишээг харна уу.

зайлшгүй шаардлагатай юм. Ил тайлагнах мэдээлэлд ТӨК-д ногдуулсан нийтийн болон төсвийн шинжтэй эрхэмлэх зорилгуудын нарийвчилсан жагсаалтыг багтаах нь зүйтэй. Үүнд:

- i Олборлох салбарын харилцааг зохицуулах үйл ажиллагаа:
 - Лиценз олгох (ОУИТБС-ын Стандартын 2.2-т лиценз олголттой холбоотой мэдээллийг ил тайлагнахыг шаарддаг)
 - Засгийн газрын өмнөөс гэрээ хэлцэл хийх, гарын үсэг зурах
 - Салбарын дүрэм журмыг боловсруулах
 - Салбарыг хянах чиг үүргийг гүйцэтгэх, үүнд хувийн компаниудын ажлын төлөвлөгөөг батлах, хяналт тавих, хууль тогтоомж, зохицуулалт, гэрээний, эсхүл үйл ажиллагаа болон байгаль орчны холбогдолтой стандартуудын хэрэгжилтэд хяналт тавих
 - Шатахуун болон бусад бүтээгдэхүүнд татаас олгох ажлыг зохион байгуулах
- ii Олборлох салбараас гаднах үйл ажиллагаа:
 - Нийтийн зориулалттай дэд бүтцийн бүтээн байгуулалт, засвар үйлчилгээг гүйцэтгэх
 - Боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээг хангах
 - Татвар хураах
 - Засгийн газрын өмнөөс авах, эргэн төлөх зээл
 - Засгийн газрын өмнөөс бусад эд хөрөнгө, бүтээгдэхүүн, үйлчилгээг нийлүүлэх²⁸
 - Газрын тос, байгалийн хий болон уул уурхайн салбараас гадуурх бизнесийн бусад үйл ажиллагаа

3) Гэрээ

Олон Улсын Валютын Сан (ОУВС), Олон Улсын Санхүүгийн Корпораци, Нээлттэй Гэрээний Түншлэл зэрэг олон улсын байгууллагууд гэрээний ил тод байдлыг хангах замаар нийтийн баялгийн менежментийн ил тод байдлыг сайжруулахыг дэмждэг. ОУИТБС-ын Стандартад тус санаачилгыг хэрэгжүүлэгч орнууд газрын тос, байгалийн хий, ашигт малтмалын ашиглалтын нөхцөлийг тодорхойлсон аливаа гэрээ, лицензийг ил тод болгохыг мөн дэмжсэн байдаг (ОУИТБС-ын Стандартын 2.4-р шаардлага).

Сүүлийн үеийн хандлагаас ажиглахад гэрээний ил тод байдал бол гол төлөв төр засгийн агентлагуудын хэрэгжүүлдэг улам бүр газар авч буй чиг хандлага болсон байна. Тухайлбал, 2017 оны БЗИ-д хамрагдсан 81 орноос 31 нь олборлох салбарын гэрээнүүдээ бүгдийг буюу (ихэнх нь) заримыг ил нийтэлсэн байв. Эдгээрээс олон гэрээг www.resourcecontracts.org цахим хуудаснаас олж үзэх боломжтой. ТӨК-уудын зүгээс өөрсдийн оролцсон гэрээг нийтлэх нь ил тод байдлыг сайжруулахад чухал хувь нэмэр болно.

Энд яригдаж буй гэрээг гурван бүлэгт хувааж авч үзэж болно. Нэгдүгээрт, ТӨК-ийн гүйцэтгэх хайгуул, олборлолт, бизнесийн бусад үйл ажиллагаатай холбоотой ТӨК, Засгийн газар хоёрын хооронд байгуулсан гэрээнүүд; хоёрдугаарт, Засгийн газрын өмнөөс ТӨК-ийн байгуулсан, төрийн холбогдох агентлагийн зүгээс ил нийтлэх боломжтой гэрээнүүд; гуравдугаарт, төсвийн орлогод материаллаг нөлөө үзүүлэхүйц, энэ утгаараа оролцогч талуудад шууд хамаатай ТӨК-ийн байгуулсан гэрээнүүд (үүнд газрын тос борлуулах гэрээ, худалдан авалтын томоохон гэрээ, хэлцлүүд гэх мэт) байна.

²⁸ Жишээлбэл, Pemex (Мексик) ТӨК-ийн цахим хуудасны "Нийгмийн хөрөнгө оруулалт" гэсэн хэсэг, <http://www.pemex.com/en/responsibility/social/Paginas/default.aspx>.

ТӨК-ийн зүгээс гэрээг ил нийтлэхдээ дараах үндсэн нөхцөлүүдийг орхигдуулахгүй байх нь зүйтэй. Үүнд:

- i Үйл ажиллагааны нөхцөлүүд
- ii Газар зүйтэй холбоотой нөхцөлүүд (өөрөөр хэлбэл гэрээ буюу лицензийн хамрах талбайн байршлын өгөгдөл мэдээлэл)
- iii Санхүүгийн нөхцөлүүд
- iv Татвар, төсөвт хамаарах нөхцөлүүд
- v Нийгмийн холбогдолтой нөхцөлүүд
- vi Хүний эрхийн холбогдолтой нөхцөлүүд
- vii Байгаль орчны холбогдолтой нөхцөлүүд

Норвегид Газрын тосны захиргаа нь Статойл болон түүний эзэмшдэг лицензийн мэдээллийг тус оронд үйл ажиллагаа явуулж буй олон улсын компаниудтай адил түвшинд ил мэдээлдэг.

The screenshot shows the FACTPAGES website interface. The main content area displays the following information:

General information

Name	Statoil Petroleum AS
Organisation number	990888213
Nation code	NO
NPDIID company	17237817

Licensees - current

Production licence	Licensee valid from date	Interest [%]
001_B	30.09.2016	50.000000
018	02.11.2009	7.604000
018_B	02.11.2009	7.604000
018_C	28.10.2011	6.654000
018_DS	30.09.2016	6.654000
025	13.01.2016	36.000000
028_B	30.09.2016	50.000000
028_C	02.11.2009	57.000000
029_B	21.12.2016	50.000000
034	02.11.2009	50.000000
035	30.09.2016	50.000000
035_C	30.09.2016	50.000000
036_BS	30.12.2013	29.443000
036_D	18.03.2017	28.853000
037	30.04.2012	21.875000
037_B	31.10.2013	51.000000

Зураг 7. Норвегийн Газрын тосны захиргаа Статойл-ийн эзэмшдэг лицензийн мэдээллийг цахим хэлбэрээр ил тод болгосон байдал

Эх сурвалж: “Тоо баримт”, Норвегийн Газрын тосны удирдах газар, хамгийн сүүлд хандсан огноо 2017 оны 12 сарын 6, <http://factpages.npd.no/factpages/default.aspx?culture=en&nav1=licence&nav2=PageView>.

БҮЛЭГ 4: ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН

ТӨК-ийн тодорхой цаг хугацаанд хэрэгжүүлсэн үндсэн болон туслах үйл ажиллагааны нэг бүрчилсэн гүйцэтгэл нь оролцогч талуудын хувьд хамгийн чухал мэдээлэл байж болзошгүй. ТӨК-ийн нөөц (өөрөөр хэлбэл нийтийн өмч)-ийн менежментэд үр дүнтэй мониторинг хийж, үнэлгээ өгөхөд тодорхой өгөгдөл, үзүүлэлтүүд шаардагдана.

1) Гүйцэтгэл

Энэ бүлгийн мэдээлэл нь Бүлэг 3-т өгүүлсэн ТӨК ямар үйл ажиллагаа явуулдаг талаарх дан тайлбараас илүү дэлгэрэнгүй байна. Тухайлбал, ТӨК өөрт хуваарилагдсан үйл ажиллагаа бүрийг ямар амжилттай биелүүлж буйг харуулахад гүйцэтгэлийн өгөгдөл мэдээлэл зориулагдан боловсруулагддаг.

Ач холбогдолтой байх үүднээс гүйцэтгэлийн мэдээлэл нь огноотой, тоогоор (хэмжээ, мөнгөн тэмдэгтийн хувьд салбарын стандарт хэмжүүрүүдийг ашиглан) илэрхийлэгдсэн, мөн цаг хугацааны хувьд жигд тайлагнагддаг бөгөөд

нарийвчлал задаргааны хувьд зохистой түвшинд байх ёстой. Тухайлбал, бүтээгдэхүүний хэмжээг олборлолт хийгдсэн талбараар танилцуулж болох агаад үүнд ТӨК-ийн гүйцэтгэлд хамаарах хувийг түншлэгчдийнхээс ялган тодотгож өгсөн байх нь чухал.²⁹ Гүйцэтгэлийг ил тайлагнахад дотоод болон хилийн чанад дахь үйл ажиллагааг хамруулах хэрэгтэй.

Ерөнхийдөө гүйцэтгэлийн өгөгдлийг ил тод болгохдоо эх сурвалж, холбогдох аргачлал, ач холбогдол бүхий тоо баримт, өөрчлөлтийг тайлбарласан тэмдэглэлийн хамтаар танилцуулах нь зохистой. Ийм тэмдэглэлд ТӨК-ийн өмнөө тавьсан зорилготой харьцуулахад гүйцэтгэл ямар байгааг уншигч ойлгоход дөхөм болох хүүрнэл тайлбарыг мөн агуулсан байх ёстой.

а. Бизнесийн үйл ажиллагаа

Бизнесийн үйл ажиллагааны гүйцэтгэлд ТӨК-ийн авч хэрэгжүүлсэн бүхий л үндсэн үйл ажиллагаа багтана. Энэ нь компанийн зүгээс ил тайлагнах гол мэдээлэл юм. БЗИ-д хамрагдсан ТӨК-уудаас бүтээгдэхүүний мэдээллийг ил тайлагнах асуудлаар талаас илүү хувь нь авбал зохих 100-гаас 75 ба түүнээс дээш оноо авсан боловч гүйцэтгэлийн бусад үзүүлэлтүүд, үүнд ялангуяа борлуулалттай холбоотой мэдээлэл дутмаг байв.³⁰

ТӨК-ийн үйл ажиллагаанаас хамааран дараах мэдээллийг ил тайлагналд хамруулах нь зүйтэй. Үүнд:

- i Нөөц: батлагдсан нөөц болон нөөцийг нөхөх харьцаа
- ii Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт
- iii Хайгуулийн үйл ажиллагаа, үр дүн (ОУИТБС-ын Стандартын 3.1-р шаардлагыг үзнэ үү)
- iv Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний төрөл тус бүрийн (ТӨК-д хамаарах хэсгийн)³¹ хэмжээ болон үнэлгээ, муж, бүс нутаг (ОУИТБС-ын Стандартын 3.2-р шаардлагыг үзнэ үү), эсхүл олборлолтын талбайгаар үзүүлсэн тайлан
- v Түүхий, боловсруулаагүй баялгийн маркетинг болон (дотоодын ба экспортын) борлуулалтын мэдээлэл³² (үнэлгээ, үнэ, олсон орлого), үүнд худалдан авагчдын нэрсийн жагсаалтыг боломжтой бол олборлолтын төсөл эсхүл талбай тус бүрээр задалсан мэдээлэл
- vi Боловсруулалт хийх хүчин чадал, гүйцэтгэл, үүнд гүйцэтгэлийн гол үзүүлэлтүүд (түүхий эдийг боловсруулах дундаж хүчин чадал, алдагдал ба нийт үйлдвэрлэлийн харьцуулалт, төлөвлөгдөөгүй сул зогсолт, нэгж бүтээгдэхүүнийг боловсруулах өртөг, шаардагдах хүн хүч, цэвэр бус ашиг)
- vii Боловсруулалт хийх бэлэн байдлын харьцаа буюу тухайн үйлдвэрийн газар жилийн хэчнээн хувьд нь боловсруулалт хийх боломжтойг харуулсан үзүүлэлт
- viii Боловсруулсан бүтээгдэхүүнийг дотоодын зах зээлд нийлүүлсэн мэдээлэл
- ix Боловсруулсан бүтээгдэхүүний импорт, экспорт

29 Тухайлбал, Статойл (Statoil) өдөр тутмын дундаж бүтээгдэхүүн, тухайн талбайд Статойлын эзэмших хувийг мэдээлдэг аж. Статойл (Statoil), 2016 оны Жилийн тайлан (2016), 22–23, 28.

30 БЗИ-д хамгийн өндөр оноо авсан Норвеги, Чили улсууд ТӨК-ийн засаглал нь ерөнхийдөө сайн үзүүлэлтэй гарсан ч борлуулалтын мэдээллийг ил болгох асуудлаар маш тааруу буюу 100 онооноос 25-г авчээ.

31 Жишээлбэл, Пемекс (Pemex) үйл ажиллагааны үр дүн, холбогдох статистик мэдээллийг 2016 оны Жилийн тайландаа тусгасныг үзэж болно (2016), [http://www.pemex.com/en/investors/financial-information/Resultados anuales/161231_reporte_i.pdf](http://www.pemex.com/en/investors/financial-information/Resultados%20anuales/161231_reporte_i.pdf).

32 The 2017 оны БЗИ-т хамрагдсан 74 ТӨК-аас зөвхөн нэг ТӨК (Йемений Газрын тос, байгалийн хийн корпораци) түүхий эдийн борлуулалтын мэдээллийг ил тод болгож буй үзүүлэлтээр сайн оноо авсан.

- x Тээвэрлэлт, хадгалалт, үүнд тээвэрлэгдсэн хэмжээ, бүтээгдэхүүнүүд, тээвэрлэлтийн материаллаг орлого (тариф гэх мэт) (ОУИТБС-ын Стандартын 4.4-р шаардлагыг үзнэ үү)
- xi Төсөл буюу олборлолт хийгдэж буй талбай тус бүрийн төлөв, үүнд байрлал, эхэлсэн огноо, сорилт бэрхшээл, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний хэмжээ, үйлдвэрлэлийн төлөвлөгөө ба төсөв, дуусах хугацаа гэх мэт мэдээлэл багтана
- xii ТӨК-ийн гүйцэтгэлтэй холбоотойгоор тодорхой цаг хугацааны хувьд хүртсэн салбарын шагнал, гэрчилгээ

Жишээ нь Коделко санхүү болон үйл ажиллагааны гол өгөгдлөө жилийн тайландаа оруулж цахим хуудсандаа байршуулж нийтэлдэг байна.



Зураг 8. Коделко ТӨК-ийн цахим хуудсандаа нийтэлсэн санхүү болон үйл ажиллагааны тоо мэдээлэл

Эх сурвалж: “Санхүү, үйл ажиллагааны мэдээлэл,” Коделко (Codelco), хамгийн сүүлд хандсан огноо 2017 оны 12 сарын 6, https://www.codelco.com/prontus_codelco/site/edic/base/port/inversiones.html.

б. Бизнесийн бус үйл ажиллагаа

ТӨК-ийн бизнесийн бус үйл ажиллагааны гүйцэтгэлийн талаарх мэдээллийг ил тайлагнахад тодорхой хугацаанд хамрах орлого болон зарцуулалтын мэдээллийг мөн хамруулах нь зүйтэй. ТӨК-ийн үйл ажиллагааны цар хүрээндээ шалтгаалаад бизнесийн бус үйл ажиллагааны гүйцэтгэлийн ил тайлагналд дараах зүйлсийг хамруулах боломжтой. Үүнд:

- i. Зохицуулах үйл ажиллагааны гүйцэтгэл
 - Олгосон болон цуцалсан лицензийн жагсаалт
 - Салбарт үйлчлэх дүрэм журмыг боловсруулахад оролцсон байдал
 - Салбарт хэрэгжүүлэх хяналт (хяналт шалгалт явуулсан статистик, тайлангууд, гэрээ болон дүрэм журам зөрчсөн тохиолдлуудын статистик мэдээ)
- ii. Олборлох салбараас гаднах үйл ажиллагааны гүйцэтгэл
 - Татаас олголт³³
 - Нийтийн зориулалттай дэд бүтцийн бүтээн байгуулалт, засвар үйлчилгээ (үүнд стратеги, таамаг тооцоо, төсөв зэрэг орно)
 - Боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ
 - Компанийн нийгмийн хариуцлагын хөтөлбөрүүд
 - Татвар хураалт
 - Засгийн газрын өмнөөс зээл авсан буюу төлсөн мэдээлэл

33 Тухайлбал, Пемексийн (Мексик) цахим хуудасны “Нийгмийн хөрөнгө оруулалт” гэсэн гарчигтай хэсэг, холбогдох статистик, http://www.pemex.com/en/responsibility/social/basic_infrastructure/Paginas/statistical_information.aspx.

- Засгийн газрын өмнөөс бусад бүтээгдэхүүн, үйлчилгээ, санхүүжилт нийлүүлсэн тухай мэдээлэл
- Олборлохоос бусад салбар дахь бизнесийн ашиг сонирхолтой холбоотой гүйцэтгэлийн мэдээлэл

в. Гүйцэтгэлийн гол үзүүлэлтүүд (ГГҮ)

ГГҮ нь бизнесийн зорилгодоо хүрэхэд чиглэсэн компанийн тодорхой мөчлөгийн үйл ажиллагааны үр дүнг үнэлэхэд тустай байдаг. Эдгээр нь компанийн гүйцэтгэлийг хэмжих багц үзүүлэлтүүд юм.

Түгээмэл хэрэглэгддэг ГГҮ-ийг дурдвал:

- i. Ашигласан капиталын дундаж дүнд ногдох өгөөж (ROACE)
- ii. Активын өгөөжийн түвшин
- iii. Хувьцаа эзэмшигчийн хөрөнгийн өгөөжийн түвшин
- iv. Авлагын эргэлтийн харьцаа
- v. Хүү, татвар, элэгдэл, хорогдол тооцохоос өмнөх ашиг
- vi. Өр зээл/хөрөнгийн харьцаа
- vii. Ногдол ашиг төлөх харьцаа

2) Санхүүгийн үр дүн

Олборлох салбарт үйл ажиллагаа явуулж буй хэд хэдэн ТӨК жилийн тайлан, түүний дотор аудитаар хянуулсан санхүүгийн тайлангуудаа тогтмол гаргадаг болсон нь санхүүгийн эрүүл байдалтай холбоотой ил тод байдлыг сайжруулахад нэн чухал юм. Санхүүгийн тайлан мэдээллийг бараг нийтэлдэггүй байсан практикаас аудитаар хянуулсан тайланг гаргах хүртэл ТӨК-уудын хувьд нэлээд цаг хугацаа зарцуулсан бөгөөд ихэнхийнх нь хувьд санхүүгийн ил тод байдлаа сайжруулах ба хангах үйл явц одоо ч үргэлжилж байна. БЗИ-д хамрагдсан ихэнх ТӨК санхүүгийн тайлагналтаар нэлээд сайн оноо авсан үзүүлэлттэй байх аж. Санхүүгийн үр дүн нь ерөнхийдөө санхүүгийн тайлагналын стандартуудтай нийцэх ёстой агаад дараах мэдээллийг нэгтгэсэн болон хэсэгчилсэн хэлбэрээр (жишээ нь охин компани бүрээр) хамруулах нь зүйтэй. Үүнд:

- i Орлогын урсгал болон тухайн тайлант хугацаанд компанийн өмнө тулгарсан сорилт бэрхшээлүүдийн танилцуулга
- ii Санхүүгийн холбогдох мэдээлэл, үүнд орлого, үйл ажиллагааны ашиг, үйл ажиллагааны зардал, хөрөнгийн зардал, цэвэр ашиг, цэвэр болон нийт өр зээл, нийт хөрөнгө болон дайчилсан хөрөнгөтэй харьцуулсан цэвэр өрийн хэмжээ зэрэг орно.
- iii Харилцан хамаарал бүхий этгээдүүдийн хооронд хийсэн хэлцэл³⁴
- iv Удирдлагын зүгээс санхүүгийн тайланг танилцуулж, гол үр дүн болон чиг хандлагыг онцолсон мэдэгдэл
- v Санхүүгийн тайлан (аудитаар хянагдсан байвал сайн), үүнд:
 - Компанийн болон охин компаниудын хөрөнгө (эзэмшлийн хувьцааны харьцааг харуулсан), өр төлбөр ба хувь нийлүүлсэн хөрөнгө (мөн гарсан өөрчлөлт) зэргийг тусгасан тайлан тэнцэл
 - Компанийн орлого, зардал, ашгийг тусгасан орлогын тайлан (ашиг, алдагдлын тайлан)
 - Компани болон төр засаг, охин компаниуд, мөн бусад талуудын хооронд гарсан бэлэн мөнгөний хөдөлгөөнийг (бонус, ногдол ашиг, хураамж, нөөц ашигласны төлбөр, татвар, зээл гэх мэт) тусгасан мөнгөн урсгалын тайлан


34 Ил тайлагналын жишээнд Энэтхэгийн хуульд нийцүүлэн гаргасан ONGC (Энэтхэг)-ийн 2015 оны жилийн тайлан (Хавсралт В, 90–92-р хуудас) нэрлэж болно. Түүнчлэн харилцан хамаарал бүхий этгээдтэй хийсэн хэлцлийг ил тайлагнахыг Олон улсын нягтлан бодох бүртгэлийн 24-р зүйлд шаарддаг.

- Санхүүгийн тайланг дагалдах нягтлан бодох бүртгэлийн аргачлал, үнэлгээний шийдвэр ба төсөөлөл, хяналтын механизм, гол тоо баримтыг онцолсон дэлгэрэнгүй тайлбар
- Аудитын тайлан

vi Мөрдлөг болгодог нягтлан бодох бүртгэлийн стандартууд

vii Зээлжих зэрэглэл (байгаа бол)

Жишээлбэл, Индонезийн ТӨК болох Пертамина цахим хуудсандаа санхүүгийн тайланг хянасан аудитын дүгнэлтийг бахаса хэлээс гадна англиар нийтэлдэг аж.



The screenshot shows the Pertamina Investor Relations website. The main navigation bar includes 'Company Profile', 'Our Business', 'News Room', 'Investor Relations', and 'Social Responsibility'. The 'Investor Relations' section is active, displaying a sidebar with 'Report & Presentation' and 'Financial Statement' options. The main content area features a 'Financial Statement' table with columns for 'Financial Year' and 'Result Announcement'. The table lists financial statements from 2012 to 2017, including 1H2017 (Unaudited) and FS 2016. A 'Press Release' section is also visible on the right side of the page.

Financial Year	Result Announcement
2017	FS 1H2017 (Unaudited)
2016	FS 1H2016 (Unaudited) FS 2016
2015	FS 2015 FS 1H2015 (Unaudited)
2014	FS 2014
2013	FS 2013
2012	FS 2012

Зураг 9. Пертамина-ийн цахим хуудсанд тавигдсан санхүүгийн тайлангууд

Эх сурвалж: “Санхүүгийн тайлангууд” Пертамина, хамгийн сүүлд хандсан огноо 2017 оны 12-р сарын 6-ны өдөр, <http://www.pertamina.com/en/investor-relations/report-presentation/financial-statement>.

БҮЛЭГ 5: ЗАСГИЙН ГАЗРЫН БОЛОН НУТГИЙН УДИРДЛАГЫН БАЙГУУЛЛАГУУДАЙ ХИЙХ ШИЛЖҮҮЛЭГ

Нийтийн баялгийг удирдах эрхийг ТӨК-уудад итгэн хүлээлгэдэг тул компанийн гүйцэтгэлээс засгийн газар хэр их өгөөж хүртэж байгаа нь хэн бүхний анхаарлыг ихээхэн татсан асуудал байдаг. ТӨК болон төрийн байгууллагуудын хооронд шилжүүлэх орлогыг ил тайлагнахыг ОУИТБС-ын Стандартын 4-р шаардлагад тусгасан байдаг. Энэ мэдээллийг зарим талаар бусад бүлэгт (тухайлбал, Бүлэг 4-т дурдсан гүйцэтгэл ба санхүүгийн үр дүнгийн хэсэгт) тайлагнаж болно. Аль бүлэг асуудлын хүрээнд тайлагнахаас үл хамааран эдгээр шилжүүлгийн талаарх мэдээллийг тодорхой байдлаар тогтмол ил тайлагнах нь ТӨК-ийн хариуцлагатай байдлын гол угтвар нөхцөл мөн.

Хамааралтай мэдээлэлд дараах зүйлс орно:

- Шилжүүлэг болон ТӨК-д үлдэх орлогыг зохицуулж буй бодлого, дүрэм журам, үүнд татварын хувь хэмжээ болон бусад тоо томъёо
- Засгийн газарт ногдох бүтээгдэхүүний борлуулалт, үүнд борлуулсан нийт хэмжээ болон түүнээс олсон орлого (ОУИТБС-ын Стандартын 4.2-р шаардлага)³⁵

35 Засгийн газарт шилжүүлэх орлогын хувийг ямар төрлийн борлуулалт гэдгээс шалтгаалж (төрд ногдох ашигт тосны борлуулалт, ТӨК-ийн эзэмших хувьцаанд харьцуулж ногдуулсан тосны борлуулалт ялгаатай) олон янзын дүрэм журмаар зохицуулж буй нөхцөлд эдгээр дүрэм журмыг тодорхой болгох шаардлагатай. Борлуулалтын мэдээллийг тайлагнахдаа шаардлагатай түвшинд задалсан хэлбэрээр хүргэх нь тустай.

- iii Төрийн сан руу шилжүүлсэн төлбөр, үүнд татвар, нөөцийн төлбөр, ногдол ашиг, шагнал урамшуулал, хураамжийн мэдээлэл багтана (ОУИТБС-ын Стандартын 4.1-р шаардлага)³⁶
- iv Төрийн бусад данс руу хийсэн шилжүүлэг
- v Орон нутгийн засаг захиргаанд хийсэн шилжүүлэг (ОУИТБС-ын Стандартын 4.6-р шаардлага)
- vi Хуримтлагдсан орлого
- vii Засгийн газрын өмнөөс хураан төвлөрүүлсэн татвар болон бусад төлбөр хураамжийн хэмжээ
- viii Засгийн газрын өмнөөс хийсэн төсвийн хөрөнгийн зарцуулалттай адил төстэй төлбөрийн хэмжээ (ОУИТБС-ын стандартын 6.2)
- ix Төрийн сан болон төрийн бусад данснаас дэмжлэг хэлбэрээр хүлээн авсан орлого (тэтгэлэг, татаас)

Төсвийн шинжтэй зарцуулалт гэх нэр томъёог нийгмийн үйлчилгээ, нийтийн дэд бүтэц, түлшний татаас, үндэсний өрийн эргэн төлөлт гэх мэт ТӨК-уудын улсын төсвөөс гадуур гаргах нийтэд зориулсан нийгмийн зарцуулалтыг хэлнэ. (ОУИТБС-ын Стандартын 6.2-р шаардлага)

БҮЛЭГ 6: ҮР НӨЛӨӨ

Сүүлийн жилүүдэд иргэний нийгэм, хувьцаа эзэмшигчдийн зүгээс санхүүгийн бус мэдээлэлд анхаарал хандуулах нь нэмэгдсэн. Ялангуяа олборлох салбарын хувьд нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөллөөс үүдэн хараа хяналтад өртөх хандлагатай байдаг. ТӨК-ууд дээрх асуудлуудыг тусгасан тогтвортой байдлын тайланг дангаар нь эсхүл жилийн тайландаа холбогдох хэсгүүдэд тусган оруулах нь улам бүр түгээмэл болж байна.³⁷ Ингэхдээ ТӨК-ууд салбарын сайн туршлагыг дагаж, үйл ажиллагаа нь нийтийн ашиг сонирхолд нийцэж буйг харуулах үүднээс аливаа болгоомжлолд хариу өгөхийн зэрэгцээ үнэт зүйлээ нийтэд тайлбарлан ойлгуулах нь чухал юм. Үүнд дараах асуудлуудыг тусгах нь зүйтэй:

- i Нийгмийн нөлөөлөл (сургалт, шилжин суурьшилт, дэд бүтэц, хөрөнгө оруулалт)-ийн үнэлгээ, нөлөөллийг бууруулах төлөвлөгөө
- ii Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, нөлөөллийг бууруулах төлөвлөгөө
- iii Ажил эрхлэлт, холбогдох чиг хандлага
- iv Эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны тайлан (осол, бууруулах төлөвлөгөө, засаж залруулах арга хэмжээний талаарх бодлого)
- v Компанийн нийгмийн хариуцлагын бодлого, хөтөлбөрүүд
- vi Нөлөөнд өртсөн бүсэд оршин суугчид гомдол гаргах механизм
- vii Орон нутгийн агууламж (орон нутгаас хийх худалдан авалт, нийтийн боловсролтой холбоотой санаачилгууд, чадавх дэмжих үйл ажиллагаа гэх мэт)

Орон нутгийн агууламж гэж баялгаас олох орлогоос гадна тухайн орон нутаг, бүс нутаг болон үндэсний эдийн засагт олборлох төслийн зүгээс бий болгох үнэ цэнийг хэлнэ.³⁸

36 Жишээлбэл, Норвегийн ТӨК Статойл (Statoil) тус улсын хуульд заасны дагуу засгийн газартшилжүүлсэн орлогоо 2016 оны Жилийн тайландаа оруулан ил тод тайлагнажээ, хуудас 248–255, <https://www.statoil.com/content/dam/statoil/documents/annual-reports/2016/statoil-2016-annual-report.pdf>.

37 Жишээ нь, Экопетрол (Ecopetrol), 2015 оны Тогтвортой байдлын тайлан, <http://www.ecopetrol.com.co/english/Ecopetrol-Sustainability-Report-2016.pdf>.

38 Байгалийн баялгийн засаглалын хүрээлэн, Орон нутгийн агууламж: Орон нутгийн эдийн засаг, ажиллах хүчнийг бэхжүүлэх нь (2015 он).

II. Мэдээллийг хэрхэн ил тод болгох вэ?

Хүртээмжтэй, найдвартай, жигд, бүрэн бүтэн бөгөөд цаг хугацааны хувьд оновчтой байх нь холбогдох мэдээллээсээ дутуугүй чухал юм. Хүртээмжгүй, хэтэрхий түвэгтэй, ерөнхий зэрэг шалтгаанаар зорилтот бүлэгтээ хүрч чадахгүй бол мэдээлэл үнэ цэнээ алдана. Түүнчлэн нягталж шалгаагүй, баталгаажуулах боломжгүй мэдээлэл нь ТӨК-д итгэх оролцогч талуудын итгэлийг нэмэгдүүлэх, хариуцлагатай байдлыг нь сайжруулахад тус нэмэр болох нь эргэлзээтэй. Нөхцөл байдлыг тайлбарлаагүй, хэсэгчилсэн, жигдрүүлээгүй мэдээлэл ил тайлагналыг сулруулж байдаг. Эцсийн дүндээ хуучирсан мэдээллээс ТӨК-ийн өнөөгийн нөхцөл байдлын талаар дүгнэлт хийх боломжгүй. Ийм эрсдэлүүдийг анхаарч ТӨК-уудад мэдээллээ ил тайлагнах аргачлалаа боловсруулахад дэмжлэг өгөх зорилгоор дараах дөрвөн гол зарчмыг танилцуулж байна.

Ил тайлагнахад ТӨК бүрд тохирох ганцхан загвар маягт эсхүл арга зам гэж байхгүй. Өнгөрсөн 10-аад жилийн хугацаанд засаглалыг сайжруулах янз бүрийн санаачилгууд гарч, баялаг ихтэй улсуудын хувьд байгалийн баялгийн менежментэд ихээхэн анхаарал хандуулах болсны үр дүнд ил тод байдалд хүрэх нэг ёсны уралдаан үүссэн бөгөөд тоолж баршгүй олон тайлан, ном, бусад эх сурвалж (сар тутмын гүйцэтгэлийн тайлан мэдээлэл, мэдээллийн товхимол, жилийн тайлан, ОУИТБС-ын тайлан, цахим хуудсууд)-ийг янз бүрийн талууд (ТӨК, яамд, бодлого боловсруулагчид, ТББ гэх мэт) эрхлэн гаргах болсон. Ерөнхийдөө ТӨК нь үйл ажиллагааныхаа бодит байдлаас хол хөндий олон тооны тайлан хэвлэхээс илүүтэй ил тайлагналын (тоо баримт цуглуулахаас эхлээд нийтлэх хүртэл) нэгдсэн стратегитай болох нь зүйтэй. Мэдээллийг цэгцтэй бөгөөд хүртээмжтэй байдлаар оролцогч талуудад хүргэхэд энэ арга барил тус дөхөм байна.

Боломжит арга замуудыг судлахдаа ТӨК оролцогч талуудын олон янз байдал болон дор танилцуулах гол зарчмуудыг харгалзан үзэх нь зүйтэй. Тухайлбал, жилийн тайлан нь зарим тодорхой мэдээллийг хувьцаа эзэмшигчдэдээ хүргэх хамгийн дөхөмтэй арга байж болох авч бусад оролцогч талуудын хувьд оновчтой арга зам биш байж болох юм. Тэрчлэн зарим мэдээллийг хойш тавилгүй ил тод болгох шаардлага тулгарахаас гадна нэлээд зардал гаргаж нийтэлдэг томоохон тайланд тодорхой тооны мэдээллийг л багтаах боломжтой. Иймд ТӨК хэвлэл мэдээллийн бусад хэлбэрүүд, үүнд тухайлбал хайлт хийх боломжтой, байнга шинэчлэгддэг цахим хуудсаар дамжуулан тоо баримтыг задаргаатай гэхдээ бас цэгцтэй байдлаар хүргэх арга механизмыг судалж үзэх нь зүйтэй.

Мэдээллийн ил тайлагналаа сайжруулах явцдаа ТӨК өөрт хамаатай нөхцөл байдал, оролцогч талуудын хэрэгцээнд тохируулан доорх гол зарчмуудыг дагах буюу мэдээллээ тайлагнах хэлбэртээ өөрчлөлт оруулах боломжтой. Үүнд:

1) Хүртээмж

Заавал шаардсан эсхүл зөвлөмж болгосон байхаас үл хамааран ТӨК-ийн ил тайлагнах мэдээлэл олон төрлийн уншигчдад ойлгомжтой, хүртээмжтэй байх ёстой.

а. Бүх оролцогч талд хүртээмжтэй байх

Хүртээмжийг ихэвчлэн нээлттэй өгөгдөл буюу аливаа зорилгоор чөлөөтэй хандаж, ашиглаж, өөрчилж, бусадтай хуваалцах боломжтой өгөгдөлтэй адилтган үзэх нь бий.³⁹ Ерөнхийдөө мэдээллийн хүртээмжтэй байдлыг үнэлэхдээ дараах асуултуудад анхаарал хандуулбал зохино.⁴⁰ Үүнд:

- i Мэдээлэлд үнэ төлбөргүй хандах боломжтой байна уу? Хэрэглэгч заавал захиалагч болох, төлбөр төлөх, зөвшөөрөл авах буюу бүртгүүлэх шаардлагагүйгээр мэдээлэл авах боломжтой байна уу?
- ii Мэдээллийг олох хялбар байна уу? Хайлтын хэрэгслийг ашиглан цахим хуудсыг олох боломжтой байна уу?
- iii Мэдээлэл хүргэж буй арга хэрэгсэл нь хэрэглэгчийн хувьд хэр хялбар байна вэ (цахим хуудас нь хайлт хийх боломжтой, тайлан нь зохион байгуулалт сайтай, агуулгыг харуулсан жагсаалттай, хайлт хийх боломжгүй зурган файл биш байх)?
- iv Өгөгдлийг хялбархан татаж авах боломж байна уу? Баримт бичигт дүн шинжилгээ хийхэд дөхөм үзүүлэх тайлбар (мета) өгөгдөл байна уу?
- v Орлого, лиценз гэх мэтийн талаарх хүснэгтэн өгөгдөл нь компьютер таньж унших боломжтой форматаар тавигдсан байна уу?
- vi Интернетгүй оролцогч талуудад холболт шаардахгүй хэлбэрээр мэдээлэл хүргэж байна уу (тухайлбал орон нутгийн салбараас авч болох жилийн тайлан, мэдээллийн хуудас, мөн туслах утас болон ажлын байранд асуулт хүлээн авч хариулах боломж гэх мэт)?
- vii Мэдээлэл нь ямар хэл дээр байна вэ? Үүнд ТӨК-ийн бүртгэлтэй болон үйл ажиллагаагаа явуулдаг улсын хэлнээс гадна англи хэл дээр байна уу?⁴¹
- viii Оролцогч талуудын сонирхсон мэдээлэл ил тайлагналд хамрагдаагүй бол хүсэлт гарган авч болох арга механизм байна уу? Үүнийг ТӨК-ийн цахим хуудсанд байх холбоо барих ерөнхий хаягаар юм уу, ТӨК-ийн олон нийттэй харилцах цахим шуудангийн хаягаар гүйцэтгэх боломжтой ба сонирхсон асуудал, оролцогч тал хэн болохоос хамааран (хувьцаа эзэмшигч, иргэний нийгмийн төлөөлөл, үйлчлүүлэгч) холбоо барих хүмүүсийн хаягийн жагсаалтыг гаргаж өгөх замаар мөн хийх боломжтой.
- ix Зарим (нөлөөлөлд өртсөн газар нутгийн оршин суугчид гэх мэт) оролцогч талуудад мэдээлэл заавал өгөх шаардлага тавигддаг бол, тэдэнд мэдээллийг хүргэх бүх боломжит арга хэмжээг авсан уу?

б. Ойлгомжтой байх

ТӨК-ийн оролцогч талуудын дунд нарийн түвэгтэй санхүүгийн тайланг ойлгох салбарын мэргэжилтнүүд, хөрөнгө оруулагчид байхаас гадна төрөөр удирдуулж буй баялгийн жинхэнэ эзэд болох иргэд, олборлох үйл ажиллагааны нөлөөнд өртсөн газар нутагт оршин суугаа иргэд мөн бий. ТӨК-ийн ил тайлагнах мэдээлэл бүх талуудад хандсан байх ёстой бөгөөд тэдний ялгавартай байдлыг харгалзан үзэх нь чухал.

39 “Нээлттэй тодорхойлолт”, Олон улсын нээлттэй мэдлэг. 2017 оны 12-р сарын 6-нд хандсан, www.opendefinition.org-г үзнэ үү.

40 Даян дэлхийн нээлттэй өгөгдлийн стандартын талаарх бидний удирдамж нь Нээлттэй өгөгдлийн тунхаг болон Санлайт сангийн зөвлөмж дээр үндэслэсэн болно. “Төр засгийн мэдээллийг нээх 10 зарчим”, Sunlight Foundation, 2017 оны 12-р сарын 6-нд хандсан, <https://sunlightfoundation.com/policy/documents/ten-open-data-principles>-г үзнэ үү.

41 Жишээлбэл, Коделко (Чили) болон Иналум (Индонези) вэб сайтаа англи хувилбараар мөн танилцуулдаг болно, <http://www.inalum.id/en>.

Мэдээллийг энгийн хэрэглэгчдэд ойлгомжтой байлгахын тулд хэд хэдэн алхмыг мөрдлөг болгох боломжтой. Үүнд:

- i. Гол нэр томъёоны тодорхойлолтыг өгч, тайлбарлах, тэдгээрийг бүх тайлан, мэдээлэлдээ жигд ашиглах
- ii. Энгийн үг хэллэг ашиглаж, мэргэжлийн үг хэллэг хэрэглэхээс зайлсхийх
- iii. Оролцогч талуудад хамаатай гол мэдээллийг онцлон тодотгох (гүйцэтгэлийн гол үзүүлэлтүүд, сүүлийн үеийн үйл явдал, чухал өөрчлөлтүүд гэх мэт)
- iv. Мэдээллийг график, видео, зураг, инфографик ашиглан харуулах

Мэргэжлийн оролцогч талуудын хувьд ил тод байдал нь нэмэлт хэв маяг шаардаж болох юм. Тухайлбал,

- v. Өгөгдлийн задаргаа (бүтээгдэхүүний хэмжээг салбар болон олборлолтын талбай тус бүрээр задалсан тоо гэх мэт)
- vi. Нарийвчилсан өгөгдөл (тухайлбал, бүтээгдэхүүний хэмжээг өдрөөр, сараар үзүүлсэн тоо)
- vii. Тайлбар (мета) өгөгдөл (тайланд дурдсан тоог ойлгоход туслах ерөнхий өгөгдөл)
- viii. Томъёонууд

Өгөгдлийг задаргаатай ил тод болгох нь сайн туршлага төдийгүй ихэнх тохиолдолд заавал дагаж биелүүлэх шаардлага байдаг. Тухайлбал, ОУИТБС-ын Стандартад тодорхой бүтээгдэхүүний үйлдвэрлэлээс төрд ногдох хувийг зарж борлуулсан мэдээллийг (борлуулсан хэмжээ, хүлээн авсан төлбөр) бусад төлбөр, орлогын урсгалын тайлантай ижил задаргаатайгаар худалдан авсан компани тус бүрээр дэлгэрэнгүй тайлагнах ёстой гэж заажээ (ОУИТБС-ын Стандартын 4.2-р шаардлага).

Дүгнэхэд, ТӨК мэдээллийг ил тайлагнах арга замаа тодорхойлохдоо янз бүрийн оролцогч талуудыг харгалзан үзэх нь зүйтэй. Ерөнхий дүн, инфографик зэргийг ашиглахаас гадна шаардлагатай үед тоо баримтын дэлгэрэнгүй задаргаа, бусад нарийвчилсан мэдээллийг орхигдуулахгүй байх нь чухал.

2) Найдвартай байдал

Ил тайлагнасан мэдээллийн үнэн зөв байдал ТӨК-ийн тоо баримт цуглуулж боловсруулалт хийх аргачлалаас хамаардаг. Ил тайлагнах мэдээллийн тоо хэмжээг олшруулахад анхаарахаас өмнө тоо баримт цуглуулж, боловсруулалт хийн баталгаажуулах зохистой аргачлалтай болох нь юу юунаас илүүтэй чухал юм. Урьд хожид байгаагүй их мэдээлэл нийтлэх гэж яараад чанарыг огоорч болохгүй. Мэдээллийн үнэн зөв, найдвартай байдлыг нэмэгдүүлэхэд тустай гурван хүчин зүйлийг дор танилцуулж байна.

а. Мэдээллийн баталгаатай эх сурвалж

ТӨК гуравдагч этгээдийн гаргасан тоо баримтыг өөрсдийн мэдээлэлд ашиглаж байгаа (тухайлбал, төрөөс баталсан ТӨК-тэй холбоотой хууль тогтоомжийг нийтэлсэн цахим хуудсыг иш татсан гэх мэт), өөрөө тоо баримтаа гаргаж байгаа нөхцөлийн аль алинд эх сурвалж баталгаатай эсэхийг нягтлах хэрэгтэй. Өөрийн тоо баримтыг ашиглаж байгаа нөхцөлд байгууллагын мэдээллийн менежментийн үйл явц нь хийгүй бөгөөд ил болгох мэдээллийг зохистой аргачлалаар цуглуулж баталгаажуулсан байх ёстой. Үүнд данс бүртгэл алдаа мадаггүй байх, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн систем нь хяналттай байх хэрэгтэй.

б. Өгөгдлийг баталгаажуулах боломж

ТӨК болон түүний тайлагнаж буй мэдээлэлд итгэх итгэлийг нэмэгдүүлэхийн тулд хүлээн авагч тухайн мэдээллээ баталгаажуулах боломжоор хангагдах ёстой. Мэдээллийн эх сурвалж (өөрөөр хэлбэл, өгөгдөл цуглуулсан аргачлал)-ийг тодорхой дурдах, огноо тавих, түүнчлэн холбогдох бусад мэдээллийг хаанаас олж авч болохыг дурдах нь уншигчид мэдээллийг давхар шалгах боломжийг олгох ач тустай байдаг. Жишээ нь экспортын зах зээлийн талаарх мэдээллийг тээврийн падаан, олон улсын гэрээ хэлцэл болон бусад эх сурвалжаас авах боломжтой. Оролцогч талууд эх сурвалж руу хандан мэдээллийн үнэн зөвийг баталгаажуулах боломжтой байвал сайн.

в. Аудит

Дотоод хяналт нь мэдээллийг нийтлэхээс өмнө үнэн зөв эсэхийг нягтлахад гол үүрэгтэй. Түүнчлэн ТӨК-ийн мэдээллийн менежментийн бодлого, практик туршлагыг байгууллагын дотоод аудитаар нягтлах нь ТӨК-ийн ил тайлагнаж буй мэдээллийн найдвартай байдлыг хангахад чухал нөлөө үзүүлнэ. Тэрчлэн бие даасан аудиторуд, түүний дотор ил тод тендерээр шалгаруулсан олон улсад нэр хүндтэй хувийн аудитын компаниудаар мэдээллийн үнэн зөв байдлыг шалгуулахын зэрэгцээ ТӨК-ийн өгөгдөл цуглуулах, дүн шинжилгээ хийх аргачлалыг үнэлүүлэх нь сайн туршлагад тооцогдоно. Тодруулбал, аудитаар баталгаажсан санхүүгийн мэдээлэл нь ТӨК-ийн удирдлагын хариуцлагыг нэмэгдүүлэхэд чухал нөлөөтэй зэрэгцээ хувьцаа нь биржээр арилжаалагддаг аж ахуйн нэгжүүдийн хувьд ихэвчлэн заавал биелүүлэх шаардлага байдаг.

3) Жигд, бүрэн бүтэн байдал

Үр дүнтэй байхын тулд ТӨК-ийн ил тайлагнаж буй мэдээлэл бүрэн гүйцэд байхын зэрэгцээ тодорхой хугацаанд жигд хэлбэртэй гардаг байх ёстой. Үүнтэй холбоотой сайн туршлагаас дурдвал:

- i Ил тайланд тодорхой хугацааг дамнуулан харьцуулалт хийж, хандлагад дүн шинжилгээ хийх боломжтой байхын тулд хэмжүүрүүдийг жигд байдлаар ашигласан байх нь чухал. Эдгээр хэмжүүрүүд нь салбарын стандартуудад (жишээ нь, газрын тосны баррелд шилжүүлсэн нэгж, дотоодын мөнгөн тэмдэгтээр илэрхийлсэн дүнг долларт хөрвүүлэх дүн гэх мэт) нийцэх ёстой бөгөөд улмаар уншигч өгөгдлийг салбарын бусад оролцогчдын мэдээлэлтэй харьцуулах нөхцөл бүрдэнэ. Цаашлаад хэмжүүрүүдийг тэдгээрт нөлөөлж болох дагалдах мэдээлэл (жишээ нь валютын ханш) буюу тайлбарын хамт хүргэх ёстой. Нэгэн жигд хэлбэрийг (Excel юмуу боловсруулалт хийх боломжтой өгөгдлийн бусад хэлбэрийн сан) ашиглах нь дөхөмтэй байж болох ба мэдээллийг ил болгохоос өмнө өгөгдөл цуглуулах үйл явцыг хялбарчлах сайн талтай.
- ii Тоон мэдээллийг хэд хэдэн жилээр танилцуулах (наад зах нь хоёр жил ба мэдээллийн найдвартай байдал цаашид нэмэгдэхтэй зэрэгцэн хугацааг уртасгах).
- iii Хэд хэдэн түвшний нэгтгэл дүнг танилцуулж уншигчдад ерөнхий ойлголт өгөхийн сацуу дүн шинжилгээ хийх нөхцөлөөр хангахын тулд илүү задаргаатай мэдээллээр хангах. Тухайлбал, санхүүгийн үр дүнгийн мэдээллийг нэгтгэж базсан байдлаар үзүүлэхийн зэрэгцээ салбар нэгж тус бүрээр тайлагнаж болох ба бүтээгдэхүүний хэмжээг олборлолт хийсэн талбай, бүс, улс, олон улсын түвшинд тус тус үзүүлэх боломжтой.

- iv Таамаглаагүй чиг хандлага, үр дүн ажиглагдсан бол тухайн нөхцөл байдлыг танилцуулж, тайлбар өгөх. Үүнд стратегид оруулсан өөрчлөлт, хувьчлал гэх мэт ТӨК-ийн дотоод үйл ажиллагаатай холбоотой үйл явдал, эсхүл санхүүгийн хямрал, валютын ханшны өөрчлөлт, олон улсын хориг гэх мэт гадаад хүчин зүйлс байж болно.
- v Өмнө нь гаргаж байсан тайлан, өгөгдлийг ил хэвээр үлдээх нь чухал.

4) Давтамж, цаг үеэ олох байдал

Хуучирсан эсхүл хэрэгтэй цаг үеэс нь хожимдуулж ил тайлагнасан мэдээлэл олон нийтэд үнэ цэнэтэй байж чадахгүй. Дараах зөвлөмжийг сайн туршлагад үндэслэн гаргасан болно:

- i Ил тайлагнах мэдээллийн давтамжийг хамрах өгөгдөлд тохируулах нь зүйтэй. Жишээ нь, зарим тоо баримт нэг жилийн дотор нэлээд өөрчлөгддөг (тухайлбал бүтээгдэхүүний хэмжээ, борлуулалтын орлого) бол зарим мэдээлэл өөрчлөгдөх нь удаан, тогтвортой байдаг (тухайлбал төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн).
- ii Цаг хугацаа алдалгүй ил тайлагнах хэрэгтэй. Ил тайлагнах мэдээлэл хоёр жилээс хуучингүй байх нь чухал. Гэхдээ ерөнхий нөхцөл байдлыг тайлбарлах, зарим хандлагыг тодруулах үүднээс хуучин мэдээллийг ил болгож болох юм. Өөрөөр хэлбэл, хуучин мэдээлэл ил байх шаардлагагүй гэсэн үг биш юм.
- iii Жилийн тайланг санхүүгийн жил дууссанаас хойш зургаан сарын дотор гаргавал зохино.
- iv Сар бүр эсхүл улирал тутамд тайлан гаргаж мэдээллээ шинэчлэхийн сацуу цахим байдлаар мэдээлэл байнга хүргэхэд анхаарах нь чухал. Үүнтэй холбоотойгоор ТӨК-ийн цахим хуудсыг тогтмол шинэчилж, анхаарч ханддаг байх ёстой.
- v Ач холбогдол бүхий үйл явдлуудыг нэн даруй мэдээлж үр нөлөөг нь тайлбарлах хэрэгтэй. Материаллаг өөрчлөлтийн тухайд цахим хуудсаар мэдээлэл түгээх нь оновчтой бөгөөд тодорхой цаг хугацаа өнгөрснийг ашиглан тухайн асуудлыг ТӨК-ийн жилийн тайланд дахин мэдээлж, дүн шинжилгээ хийх боломжтой.

ТАЛАРХАЛ

Энэхүү хөтчийг боловсруулахад Камилле Оберкампийн судалгаа ихээхэн тустай байв.

Байгалийн баялгийн засаглалын хүрээлэн нь бодлогын судалгаа хийх, чадавх хөгжүүлэх, техникийн туслалцаа үзүүлэх, нөлөөллийн үйл ажиллагааг дэмжих замаар тухайн улс орны иргэд газрын тос, байгалийн хий, уул уурхайн баялгийнхаа үр шимийг хүртэхэд туслалцаа үзүүлдэг олон улсын хараат бус, ашгийн бус байгууллага юм.

Нэмэлт мэдээллийг www.resourcegovernance.org вэбсайтаас авна уу.